

Улаанбаатар: ӨНӨӨДӨР

Өдөр -16
Шөнө -27

УЛС ТӨР

Я.САНЖМЯТАВ: ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ УИХ-Д СУУДАЛГУЙ НАМУУДАД ХАМААРЛТАЙ

II нүүрт

СПОРТ

П.ОРХОН: ӨРСӨЛДӨӨН ИХТЭЙ ЖИНГИЙН ТАМИРЧДААС Л ӨНДӨР АМЖИЛТ ГАРНА, ТИЙМДЭЭ Ч БИ 63 КГ-ЫГ СОНГОСОН

VI-VII нүүрт

Дугаарын **60** мөр

Хүүхэд нийгмийн сүлжээний хохирогч биш

Б.СУМЬЯА

Юуны өмнө нэгэн түүх сөхье. Нэгэн америк эмэгтэй фэйсбүүк хуудастаа охиныхоо зургийг нийтэлжээ. Ингэхдээ хэдэн настай, хаана сурдаг гэх мэт хүүхдийнхээ хувийн чанартай бүхний л мэдээллийг нь дэлгэж. Хүүхдийнхээ өхөөрдөм, хайр татам үйл хөдлөл, дүрсгүйтсэн зургийг нийгмийн сүлжээнд нийтлэн найз нөхөд, хамаатан садандаа харуулахдаа тэр бүсгүй охиноо хорлож байгаагаа төсөөлөө ч үгүй биз. Гэтэл нэг л өдөр охин нь алга болж, хүний наймаачдын гарт орж, эх нь ч амьдын тамд унажээ. Энэ явдал өнгөрсөн онд гарч байлаа. Алс холын Америкт болсон ч гэлээ, манайд болохгүй гэх баталгаа байхгүй юм. Саяхны судалгааны дүнгээр сошиал медиа хэрэглэгчдийн тоо дэлхий даяар 2.34 тэрбумд хүрсэн байх бөгөөд 2020 он гэхэд гурван тэрбумд хүрнэ гэсэн тооцоо гарсан байдаг.

Үргэлжлэл нь III нүүрт

ҮЗЭЛ БОДОЛ

ХЭНЮУХЭЛЭВ

Э.ТУУЛ

Өнгөрсөн долоо хоногт олон үйл явдал болж өнгөрлөө. Хамгийн их анхаарал татсан сэдэв утаа байсан бөгөөд энэ асуудлаар салбар яам болон төр засгийн өндөрлөгүүд, ҮАБЗ, Монгол Улсын Ерөнхийлөгч ч байр сууриа илэрхийлж, анхаарал хандуулж эхэллээ. Түүнчлэн ХЗДХЯ-наас боловсруулж, өргөн мэдүүлсэн хуулийн төслөө олон нийтэд танилцуулах зорилгоор “Хууль төрөхийн өмнө” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулж, Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг танилцууллаа. Мөн өнөөдөр Монгол Улсын шинэ Үндсэн хууль батлагдсаны 25 жилийн ой тохиож байна. БНМАУ-ын Ардын Их Хурлын хуралдаанаар “Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийн тухай” хууль баталж, Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг жил бүрийн нэгдүгээр сарын 13-нд тэмдэглэн өнгөрүүлж байхаар тогтсон байдаг билээ. Үүнээс гадна Антарктид тивийн ноён оргил болох Винсон Массифын оройд гарч, дэлхийн долоон тивийн ноён оргилыг эзэлж, “Seven Summits” хэмээх түүхэн амжилтын эзэн болсон ОУХМ, МУГТ Б.Гангаамаа эх орондоо хүрэлцэн ирсэн зэрэг олон үйл явдал өрнөсөн долоо хоног байлаа.

Ц.Элбэгдорж: Аюултай орчин байгаа бол энд хязгаарлалт хийхээс өөр арга байхгүй

/Монгол Улсын Ерөнхийлөгч/

Нийслэлийн агаар, орчны бохирдлын асуудлаар ҮАБЗ-ийн өргөтгөсөн

хуралдааны дараа Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж мэдээлэл хийлээ. Энэ үеэрээ тэрбээр “Нийслэл хотын агаар, орчны бохирдлын асуудлыг өчигдөр Үндэсний аюулгүй байдлын зөвлөл өргөтгөсөн хурлаар авч хэлэлцсэн. Хуралдаанд төрийн өндөрлөгүүд, сайдууд, УИХ-ын гишүүд, хотын удирдлагууд оролцсон.

Үргэлжлэл нь III нүүрт



Н.Алтанхуягийн паян НАМАА ЯЛАГДУУЛАХ



ТОМ ШАЛТГААНЫ нэг байсан шүү гээ

АН-ыг ялагдалд хүргэсэн ялыг үүрэлцэх учиртай хүмүүсийн тоонд зүй ёсоор орох хүмүүсийн нэг нь АН-ын дарга асан Н.Алтанхуяг гэдгийг хэлэх хүн цөөнгүй байдаг. Гэтэл одоо ял үүрэх нь битгий хэл ямба эдлэхээр намын даргад дахин санаархаж нэр дэвшээд тууж явна. Уг нь тэрбээр АН-ын даргаар хамгийн олон жил ажилласан, тэр ч байтугай өнгөрсөн дөрвөн жилийн хоёрт нь Засгийн газрыг тэргүүлж, байсан. Харин одоо “намаа цэвэрших ёстой, нэг хүнээс хараат байх ёсгүй, фракцигүй байх хэрэгтэй,

шударга бүхний төлөө” хэмээн уриа лоозон болж яваа нэгэн. Гэтэл АН-д фракци гэдэг ойлголтыг хамгийн ихээр шингээж, гишүүдээ өөр хооронд нь талцуулсан нөхөр бол Н.Алтанхуяг гээд хэлчихэд хилсдэхгүй. Түүний тэргүүдэг Алтангадаас гэдэг фракци өнөөдөр намдаа байтугай улс орон даяар алдартай. Энд өөр намын нөхдүүд ч байдаг гэж байгаа. Түүний хэлээд байгаа шиг “Хэсэг бүлэгт хуваагдаж эрх мэдлийн төлөө зүтгэнэ” гэдэг хар үйлийг яаж хийдэг гэдгийг энэ фракци л өнгөрсөн хугацаанд яруу тодоор харуулж ирсэн. Түүний эргэн тойрондох хүмүүсийг хууль хяналтын байгууллагуынхан шалгаж байгаа нь үнэн. Овоо босгоогүй бол шаазгай хаанаас суух вэ гэдэг. Ерөнхий сайд байхдаа хүргэн

Дэнзэнгээ өндөр албан тушаалд тавьж, тэр нь мөнгө төгрөгийн хэрэгт холбогдсон нь өнгөрсөн УИХ-ын сонгуулиар АН-ын “үсгүй” ялагдах шалтгааны томд орох учиртай. Ер нь намын даргын төлөө нийнхүү улайрч байгаа нь учир мэдэх хүмүүс хууль хяналтынхнаас булгах гэсэн башир арга ч гэж үзэх юм билээ. Тиймээс ичих нүүртэй байгаач гэж намынхан нь зөвлөж байгаа ч тэрбээр үл тоож буй. АН-ын шинэчлэл гэдэг бол зөвхөн ганц намын асуудал бус. Монгол Улсын ардчиллын асуудал. Тиймээс хэн нэгний бохир нэр төрөө сэргээдэг, түр хоргодох байр биш байлтай, энэ АН. Мөн өөр бусад нөхөд өөрийгөө хамгаалах хэргээс болгож байгаа нь ч нууц биш гэдгийг хэн хүнгүй хэлж байгаа билээ.

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА



1900-1234 ДУГААР ТАНЫ ДОТНЫ ТУСЛАХ БОЛЖ ЧАДНА

Н.БАТЗАЯА

Хөдөө, орон нутагт хот хоорондын зорчигчтээврийн автобусаар явнагэдэг хэдхэн жилийн өмнө хэцүүхэн даваа байлаа. Тэр дундаа, хот хоорондын зорчигч тээврийн автобусны тасалбар олж авах гэж нэлээд цаг хугацаа алдана. Аль нэгэн аймаг руу явахын тулд заавал урд өдөр нь аль эсвэл өглөөний нартай уралдан босч тасалбар авдаг байсан цаг саяхных. Гэхдээ технологийн дэвшлийг төрийн үйлчилгээнд нэвтрүүлснээр иргэдэд учрах энэхүү хүндрэл, чирэгдэл, хүнд суртал ариалад нэг жилийн хугацаа өнгөрчээ. Тодруулаад хэлбэл, Автотээврийн үндэсний төвийн Хөдөлгөөний хяналтын хэлтэст 1900-1234 хэмээх тусгай дугаарын утас ажиллаж эхэлснээр авто зам болон зорчигч тээвэрлэлттэй холбоотой зарим үйлчилгээг онлайн аргаар иргэдэд хүргэх боломжтой болжээ. Тиймээс Автотээврийн үндэсний төвийн Хөдөлгөөний хяналтын хэлтсийн лавлах төвөөс энэ удаагийн өдрийн сурвалжлагаа бэлтгэжээ. Автотээврийн үндэсний төвийн хоёр давхарт байрлах Хөдөлгөөний хяналтын хэлтэст суурин утас тасралтгүй дуугарах аж. Энэ бол иргэдэд хэрэгтэй зөвлөгөө, мэдээллийг хүргэдэг 1900-1234 тусгай дугаарын утас гэнэ. Энэхүү лавлах утсанд одоогийн байдлаар таван мэргэжилтэн ажиллаж, иргэдэд хэрэгтэй мэдээллийг өгч байгаа талаар тус хэлтсийн ахлах мэргэжилтэн Б.Мөнхчулуун онцолж байв. Мөн 1900-1234 тусгай дугаарт

холбогдох иргэдийн тоо ихэссэнээс болж ачаалал нь нэмэгдсэн байна. Үүнтэй холбогдуулан лавлах утасны мэргэжилтнүүдийн тоог нэмэх арга хэмжээг цаашид авахаар бэлтгэж байгаа юм байна. Биднийг ийн ярилцаж зогсолт утас дуугарч байна. “Миний машиныг “ruis 20” маркийн машин хааж зогсчихоод утасны дугаараа үлдээгээгүй байна. Эзэнтэй нь холбож өгөөч” хэмээх иргэний дуудлага орж ирэв. Тэр даруйд үйлчилгээний ажилтан тухайн машины улсын дугаараар ямар компани, иргэнд харьяалалтайг нь мэдэн дуудлага өгсөн иргэнтэй шууд холбож өглөө. Энгийнээр хэлэхэд, операторууд тухайн автомашиныг улсын дугаараар нь шүүж, эзнийг нь тогтоогоод хэрэглэгчтэй шууд холбох үйлчилгээ үзүүлдэг гэнэ. Ингэснээр иргэнд түргэн шуурхай үйлчилгээг хүргэж чаддаг байна. Энэ бол 1900-1234 тусгай дугаарын үйлчилгээнээс авч болох бас нэгэн үйлчилгээ нь ажээ. Иргэд бусдын автомашиныг хааж, холбоо барих утасны дугаараа үлдээгээгүй явсан тээврийнхэрэгслийн эзэмшигчтэй Автотээврийн үндэсний төвийн 1900-1234 лавлах утас руу залгаж, холбогдох боломжтой болсон байна. Дараагийн нэгэн онцлох үйлчилгээ нь байршил тогтоох үйлчилгээ аж. Тухайлбал, улс, хот хоорондын зорчигч тээврийн автобус хаана явж байгааг мэдэхийг хүсвэл тусгай дугаарт хандаж авах боломжтой гэдгийг мэргэжилтнүүд онцолж байлаа.

Үргэлжлэл нь V нүүрт

Таны тэр бүлийн хамгийн зөв сонголт

100% Байгалийн цэвэр ЯПОН шүүс ДЭЭД Сорт

50,000 ₮-с дээш Хүргэлт үнэгүй

Хүргэлтийн утас: 99904283

И-март, Home Plaza, 3-гал худалдааны төв В1, Шарга төв /3-р хороолол/, АСА циркийн баруун урд Эмон 18/3 байр

Since 1899

ХААН банк				Хугалгаа хөгжлийн банк				
	Авах	Зарах		Авах	Зарах		Авах	Зарах
АМ.ДОЛЛАР	2494.00	2505.00	ФУНТ	3017.00	3117.00	АМ.ДОЛЛАР	2493.00	2505.00
ЕВРО	2624.00	2692.00	РУБЛЬ	40.30	43.80	ЕВРО	2625.00	2699.00
ИЕН	21.69	22.17	ЮАНЬ	359.00	365.40	ИЕН	21.61	22.24
						ФУНТ	3027.00	3111.00
						РУБЛЬ	40.64	44.43
						ЮАНЬ	359.00	364.40

Өчигдрийн 19.00 цагийн байдлаар

УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

ЧУУЛГАНЫ ТАНХИМААС

Сонгинохайрхан дүүрэгт төсөл бичих сургалт эхэллээ

УИХ-ын гишүүн Н.Учрал өөрийн сонгогдсон тойргийнхоо иргэдийн дунд “Шинэ санаа-Нар зөв хөгжил 2020” сэдэвт төслийн уралдааныг зарласан. Уг төслийн уралдааны хүрээнд Сонгинохайрхан дүүргийн “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”-тай хамтран төсөл бичих сургалтыг эхлүүлээд байна. Уг сургалтыг өнгөрсөн даваа гаригаас албан ёсоор эхлүүлсэн бөгөөд тус дүүргийн 32 хорооны иргэд хамрагдаж юм.

Иргэд сургалтад хамрагд-санаар стандартад нийцсэн төслийг бичих чадвартай болно. Сонгинохайрхан дүүргийн иргэдээс төсөл бичихэд дэмжлэг үзүүлэх хуулийг иргүүлсэн учраас энэхүү сургалтыг эхлүүлжээ. Сургалт богино хугацаанд үргэлжлэх бөгөөд нийт 11 удаагийн сургалтыг хоёрдугаар сарын сүүл хүртэл зохион байгуулна. Сургалтад хамрагдахыг хүссэн иргэд Сонгинохайрхан дүүргийн “Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сан”, Н.Учрал гишүүний бие төлөөлөгч Н.Ганхуяг /94119470/ нартай холбогдох юм байна. УИХ-ын гишүүн Н.Учрал уг сургалтын төвд очиж ажиллан үйл ажиллагаатай нь танилцлаа. Тэрбээр энэ үеэр “Энэхүү сургалтад хамрагдсанаар яамд, төрийн болон төрийн бус байгууллага болон улсын байгууллагад төсөл бичих чадвартай болж төгсөх юм. Үнэхээр үндэсний үйлдвэрлэл, импортыг орлох, ажлын байрыг нэмэгдүүлэх чиглэлээр сайн төсөл бичвэл шилдэг төслийн уралдаанд шалгаруулахаас гадна цаашид холбогдох байгууллагуудтай нь холбож ажиллана” гэлээ.

Я.САНЖМЯТАВ: ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛЬ УИХ-Д СУУДАЛГУЙ НАМУУДАД ХАМААРАЛТАЙ



Ж.ОТГОН

УИХ-ын чуулганы хуралдаанаар Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын тогтоолын төсөл, Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл зэрэг 17 асуудлыг хэлэлцэхээр товловсон. Хурлын эхэнд хэлэлцэх асуудал дунд багтсан Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг хэлэлцэх асуудлаар АН-ын бүлгийн гишүүн Я.Санжмятав завсарлага авах санал гаргалаа. Тэрбээр “Ерөнхийлөгчийн сонгуульд УИХ-д бүлэгтэй намуудаас нэр дэвшигч нэрээ дэвшүүлэх эрхтэй байдаг. Гэсэн хэдий ч Монгол Улсын Ерөнхийлөгч бусад УИХ-д суудалгүй намуудад хамааралтай сонгууль. Нийт ард түмнээрээ хэлэлцэж сонгодог томоохон сонгууль юм. Тиймээс АН-ын билэг Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төслийг хэлэлцүүлэхээс өмнө УИХ-д суудалгүй намуудтай ярилцаж, зөвлөлдөж асуудлаа шийдэх нь харин цаг хугацаа хожиж хурдан хугацаанд багтагдах магадлал өндөр гэж үзлээ. Шаардлагатай тохиолдолд зарим зүйлийг ажлын хэсгийн хүрээнд засч залруулаад оруулах бололцоотой гэж бодож байна” хэмээн завсарлага авах шалтгаанаа тайлбарлав. Хэлэлцэх асуудалтай холбогдуулан гишүүд санал хэлсний дараа УИХ-ын дарга М.Энхболд АН-ын бүлгийн саналыг хүлээн авч, нэг хоногийн завсарлага өгч байгааг танилцуулав. Ингэснээр өнөөдөр уг хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийхээр болж хойшлууллаа.

СЕХ-ны гишүүнээр Ө.Энхтөрийг томилов

УИХ-ын чуулганы хуралдаан СЕХ-ны гишүүнийг

чөлөөлөх, томилох асуудлыг хэлэлцлээ. Сонгуулийн ерөнхий хорооны гишүүн Д.Дэлгэрдцогтыг чөлөөлж, түүний оронд Цагдаагийн ерөнхий газрын дарга Ө.Энхтөрийг томиллоо. Мөн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий аудитор А.Зангадыг чөлөөлөх, түүний оронд Д.Хүрэлбаатарыг томилох асуудлыг хэлэлцлээ. УИХ-ын гишүүд санал хэлсний дараа Д.Зангадыг үүрэгт ажлаас нь чөлөөлөхийг гишүүдийн олонхи дэмжсэн тул Д.Хүрэлбаатарыг Монгол Улсын Ерөнхий аудиторгоор томиллоо. Чуулганы хуралдаанаар хэлэлцсэн өөр нэг томилгоо бол Монголбанкны хяналтын зөвлөлийн дарга, гишүүдийг чөлөөлөх асуудал байв.

Монголбанкны хяналтын зөвлөлийн даргаар МУИС-ийн Олонулынхарилцаа,нийгмийн удирдлагын сургуулийн ахлах багш Д.Даваасамбуу, гишүүдэд Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын удирдах зөвлөлийн дарга, ерөнхийлөгч Б.Лхагважав, “Их Амар” группийн ерөнхийлөгч М.Энх-Амгалан, Удирдлагын

академийн тэнхмийн эрхлэгч Л.Ариунаа,Өмгөөллийн“Эрхэм хуульч” нөхөрлөлийн гүйцэтгэх захирал, хуульч Б.Цэрэнбалтав, Монголын нягтлан бодох бүртгэлийн хүрээлэнгийн тэргүүн Л.Дондог, Монголын мэргэшсэн нягтлан бодох бүртгэлийн институтын гүйцэтгэх захирал Ч.Чимидсүрэн нарыг томилло.

Шийтгэлийг давхардуулж ногдуулахгүй боллоо

УИХ-ын чуулганы үдээс хойшхи нэгдсэн хуралдаанаар Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон Захиргааны харилцааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг хэлэлцээд гишүүдийн олонхи дэмжсэнээр төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох байнгын хороонд шилжүүлжээ. УИХ-аас өнгөрсөн онд Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн төслийг шинэчлэн баталсан ч зөрчил гаргасан этгээдэд ногдуулах

зарим үндсэн шийтгэл давхардаж оногдохоор болсон нь зөрчил үүсгээд байсан юм. Эл зөрчлийг арилгахын тулд Засгийн газраас Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар болж, төслийг өргөн мэдүүлсэн. УИХ-аас дээрх хуулийг баталсан нөхцөлд согтууруулах ундаа, мансууруулах эм, сэтгэцэт нөлөөт бодис хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодсон бол Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2-4 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгож, долоо хоногоос 30 хоног хүртэл хугацаагаар баривчлах шийтгэл ногдуулаа гэж давхардсан харилцаагаар хүлээлгэхээр байсан нь цуцлагдаж, зөвхөн нэг л шийтгэлийг хүлээлгэхээр болж, өөрчлөгдөх юм. Мөн хуралдаанаар Арбитрын тухай хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг хийж дуусган, эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох байнгын хороонд шилжүүлжээ.

Дугаар шилжих төчид чуулганы нэгдсэн хуралдаан үргэлжилж байна.

МОНГОЛЫН МЭДЭЭ
19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч: С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч: Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ 99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга: Э.ЭНХЦЭЦЭГ 90873012

Ахлах редактор: Б.ӨНӨРТӨГТӨХ 88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба: Н.ПУНЦАГБОЛД 88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба: Б.ӨНӨРТӨГТӨХ 88006842

Гэрэл зургийн алба: Г.АГУУЖИН 96017873

Компьютерийн алба: Б.ГАНЗОРИГ 99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба: Н.АЛТАНЦЭЦЭГ 99173710

Захиалга, борлуулалтын алба: М.ДАВААДУЛАМ 99042510

Э.САЙНЗАЯА 99197866

Дугаарыг эрхлэсэн Э.ЭНХЦЭЦЭГ


Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/, 2 давхар, 209, 211 тоот

Харилцах утас, факс: 976-70113551

“Монголын мэдээ” сонины редакцт эхийг бэлтгэж, “Чөлөөт хэвлэл сан”-ийн хэвлэл үйлдвэрт хэвлэв.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ



Д.Ганбат: Нисэх буудлын үйл ажиллагааг эдийн засгийн үр ашигтай байдлаар зохион байгуулна

Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Такаока Масатог хүлээн авч уулзлаа. Уулзалтын үеэр сайд Д.Ганбат “Манай хоёр улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагаа нийгэм, эдийн засаг, дэд бүтэц, соёл, боловсрол зэрэг олон салбарт өргөжин хөгжиж байна. Дэд бүтцийн салбар, тэр дундаа зам, тээврийн салбарын харилцаа, хамтын ажиллагаа улам бэхжиж байгаад баяртай байна” гэв. Мөн Монгол-Японы Засгийн газар хооронд агаарын тээврийн салбарт амжилттай хэрэгжүүлж байгаа Улаанбаатар хотын олон улсын шинэ нисэх буудлыг бүс нутгийн өрсөлдөх чадвар бүхий зангилаа төв болгон

хөгжүүлэх зорилт тавин ажиллаж байгаа талаараа танилцуулсан юм. Энэ хүрээнд Чингис хаан олон улсын нисэх буудлын арилжааны нислэгийн үйл ажиллагааг шинэ нисэх буудалд шилжүүлж, нисэх буудлын үйл ажиллагааг эдийн засгийн үр ашигтай байлгах арга хэмжээг авч ажиллана гэдгийг хэлж байв.

Харин Япон Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Такаока Масато хоёр орны зам, тээврийн салбар дахь хамтын ажиллагааг өргөн хүрээнд танилцуулсанд талархаж, цаашид харилцан уялдаа холбоотой ажиллаж, зам, тээврийн харилцаагаа улам өргөжүүлэх чиглэлд хамтран ажиллахаа илэрхийлсэн.

Удирдах ажилтнуудад хариуцлагатай ажиллахыг үүрэгдлээ

Хүнс, хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн тус яамны хурлын танхимд эхэллээ. Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг энэ удаагийн зөвлөгөөнд ХХААХУ-ийн сайд П.Сэргэлэн, дэд сайд Ж.Сауле, Төрийн нарийн бичгийн дарга Л.Баяртулга, ХХААХУЯ, харьяа газар, хэлтсийн дарга нар болон 21 аймгийн ХХААГ-ын дарга, албагын дарга нар оролцлоо. Зөвлөгөөнийг нээж ХХААХУ-ийн сайд П.Сэргэлэн үг хэллээ. Тэрбээр “Өнөөдрийн үйл ажиллагаа бол 100 хувь ажил хэргийн уулзалт зөвлөгөөн юм. ХХААХУ-ийн салбарын улсын зөвлөгөөнөөр Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны ХХААХУЯ-ны салбарт зорилго болгон тавьсан зорилтуудыг хэрэгжүүлэх,

үйл ажиллагаагаа хэрхэн зохион байгуулах, уялдуулж хийх талаар ярилцах ажил хэргийн уулзалт. Өнөөдрийн хурал баярын хурал биш, ойн баяр биш. Тийм учраас цэвэр ажил хэрэг ярьсан, ирэх он жилүүдэд аймаг орон нутгийн удирдлагуудтай хэрхэн хамтарч ажиллах тухайгаа ярилцаж тохирох юм. Өнөөдөр санал шүүмжлэл, шаардлага, сахилга бат ярина. Цаашдаа Монгол Улс эдгээр зорилго зорилтуудаа хэрэгжүүлэхийн тулд харилцаагаатай, хяналттай байх ёстой. Тийм учраас өнөөдөр орон нутаг болон харьяа газрын удирдлагуудтай уулзаж байна” гэв. ХХААХУ-ийн салбарын удирдах ажилтны зөвлөгөөн хоёр өдөр үргэлжлэх бөгөөд салбарын сургалт-семинараар үргэлжлэн явагдах юм байна.

“Баруун талдаа хүртэй автомашиныг хориглоогүй”

Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат болон Автотээврийн үндэсний төвийн холбогдох албаныхантай очигдөр Сонгинохайрхан дүүргийн Автотээврийн техникийн хяналт, үзлэгийн төвийн үйл ажиллагаатай танилцлаа. Энэ үеэр Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат “Засгийн газрын хуралдаанаар баруун талдаа жолооны хүртэй тээврийн хэрэгслийн импортыг хязгаарлах, насжилт өндөртэй тээврийн хэрэгсэлд хяналт тавих танилцуулга хийсэн. Мөн үүнтэй холбогдуулан Улаанбаатар хотын агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр ЗТХЯ-аас анхаарч, хэд хэдэн арга хэмжээг зохион байгуулж байгаа талаараа салбарын сайд танилцууллаа. Тэрээр “Автомашингаас ялгарах утааг багасгах, автомашины хяналтын үзлэгийн чанарыг сайжруулах үүднээс шат дараатай арга хэмжээ авч



ажиллаж байна. Мөн Монгол Улсад нийт 284 суудлын вагон ашиглагдаж байгаа бөгөөд жилд 1000 гаруй тонн нүүрс ашиглаж байна. Тиймээс утаагүй түлшнийг ашиглах тушаал шийдвэрийг гаргалаа” гэв. Түүнчлэн баруун талдаа хүртэй, өндөр насжилттай автомашиныг хязгаарлах, татварын бодлогоор зохицуулах саналыг Сангийн

яаманд хүргүүлээд байгаа аж. Улаанбаатар хотод хөдөлгөөнд оролцож буй 400 мянган тээврийн хэрэгслийг судлаад үзэхэд баруун талдаа хүртэй, өндөр насжилттай автомашиныуд дийлэнх хувийг эзлэж байгаа бодлогоор зохицуулах шаардлагатай байгааг энэ үеэр албаныхан онцолж байв.

ҮЗЭЛ БОДОЛ

ХЭН ЮУ ХЭЛЭВ



байна, ялын бодлогоо чангална гэдэг бодлогоо Эрүүгийн хуульд нэмэлт өөрчлөлтийн төсөлд хатуу зааж өгсөн” хэмээсэн юм.

П.Улаанхүү: Үндсэн хууль хэнд гай болсон юм

/Улсын Бага хурлын гишүүн/

Үндсэн хуулийн 25 жилийн ойн өдөр тохиож буйтай холбогдуулан Улсын Бага хурлын гишүүн П.Улаанхүү байр сууриа илэрхийлжээ. Тэрбээр “Одоогоос 25 жилийн өмнө, тухайн үед сум бүрээс нэг хүний төлөөлөгчөөс бүрдсэн 430 депутат шинэ Үндсэн хуулийн 76 хоног хэлэлцэн баталж байсан түүхтэй. Ардчилсан хувьсгал 1990 онд гарсны дараа Монголын өөрчлөлт шинэчлэлтийн бүх улс төрийн хүчнүүд тохиролцсон нэг үр дүн бол шинэ Үндсэн хууль байв. Өнөөдрийн бидний нийгмийн амьдралыг зохицуулж буй гол зүйл бол Үндсэн хууль. Үүнийг батлалцахад олон улс төрийн хүчний зөвшилцөл хамгийн чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Хэцүү үе их байсан. Бид АИХ-ын танхимд үг хэлж, хуулиа тайлбарладаг байлаа. Тэгэхэд биднийг шоолж инээхээс эхлээд үг хэлж байхад хажуу талаас цохиж “суу” гэж хэлэх тохиолдол ч гарч байсан. Хэдийгээр тоглоом шоглоомоор ийм үйлдэл гаргадаг байсан ч, нэг талаараа тэр чинь дарамт шүү дээ. Хуулийн зүйл заалтаа тайлбарлаж, ерөнхийдөө танин мэдэхүйн мэдээлэл их өгч байсан шүү. Үндсэн хуулийн зарим зүйл заалт буцаж, түүнийгээ дэмжүүлэхийн тулд дахин дахин тайлбарлаж, батлуулж байсан нь ч бий. 1990 онд Улсын Бага хурлыг хаяж гарч байсан. Энэ их утга учиртай зүйл. Бага хурлаар хамгийн анх Хөдөлмөрийнхуулийг хэлэлцсэн юм. Энэ хуульд тэмдэглэлт баярын өдрүүдийн асуудал багтсан байв. Бага хурлаар арваннэгдүгээр сарын 7-нд Октябрийн баярыг тэмдэглэх тухай яригдахад би “Энэ баярыг тэмдэглэхгүй ээ, хүний баяр. Бид өөрсдийн баяраа тэмдэглэх хэрэгтэй. Тусгаар тогтнолыг тунхаглан зарласан арваннэгдүгээр сарын 26-ны өдрийг тэмдэглэж, амралтын өдөр болгоё” гэж саналаа хэлж байсан юм. Тэгтэл гишүүд эсэргүүцэж эхэлсэн л дээ. Тэгэхээр нь Ардчилсан нам хурал хаяж байлаа. Монголын парламентын түүхэнд анх удаа хурал хаясан үйл явдал болж байв. Тухайн үед тэмцэж эсэргүүцэж байж арваннэгдүгээр сарын 26-ныг тэмдэглэлт өдөр болгож байхад сүүлд болнуулсан их эмзэгээр хүлээж авсан шүү. Өөрсдөө оруулчихаад эцэст нь болуулж болохгүй л дээ. Харин өнөөдрийн нөхцөлд Үндсэн хуульд өөрчлөлт оруулж болохгүй. Ийм тэнцвэргүй нөхцөлд одоогийн 76 гишүүн Үндсэн хуульд өөрчлөлт оруулбал өөрсдийнхөө эрх ашгт нийцүүлж л өөрчилнө. Олон намын төлөөлөл санал солилцож, зөвшилцсөний эцэст эх хуульд



хүмүүс явдаг юм билээ. Би залууд цагаан тив л байх юм байх гэж бодсон чинь маш том мэдээллийн бээм байсан. Гурван чиглэл гэхээр, Өмнөд туйл руу нислэг хийдэг. Туйл руу явж байгаа судлаачид, жуулчид гээд бүх хүмүүст зориулж нислэг хийдэг юм байна. Нөгөө нэг нь Винсон Массиф уул руу чиглэсэн нислэг. Гурав дахь нь эх газар руу эргэж нисдэг нислэг үйлддэг юм билээ. Би эндээс явахын өмнө хэлж байсан даа, Оросын багтай хамтарч авиралтаа хийнэ гэж. Манай багт Оросын “7 Summits” клубын зохион байгуулалт дор нэгдэж очсон туйлын болон уулчдын нэгдсэн 11 хүн багтсан. Манай Винсон Массиф ууланд авирах хүмүүс дөрвөн авирагч, нэг хөтөч, нэг туслахтайгаар зургуулаа явсан. Пунта-Аренасаас арванхоёрдугаар сарын 18-ны өдөр Антарктид тив рүү ниссэн. Зургаан цаг нисч Антарктид тивд хүрсэн. 19-ний өндөр Винсон Массиф уул руу ниссэн. Зургаан цаг хийж онгоцоор ниссэн. Улмаар 20-ны өдрөөс эхлээд л бага багаар авиралтаа эхлүүлсэн. Чилийн цагаар 25-ны өдрийн 12:00 цагийн үед оргил руу авиралтаа эхлүүлсэн. Оргил хүртэл 7 км зам туулах ёстой байсан. Бид Чилийн цагаар 19:15 цагийн үед оргил дээр гарсан. Оргил дээр маш хүйтэн, салхи ихтэй байсан учраас ахлах хөтөч маань хурдан буухыг сануулсан. Ингээд л оргил дээр дөнгөж гараад л буусан даа. Антарктид тивийн уур амьсгал маш их хуурай. Тэнд ямар ч чийг байхгүй. Яагаад гэвэл тэнд ногоон ургамал гэж байхгүй. Мөн бороо орж байж, эсвэл цас хайлж гэмээр чийгтэй болно шүү дээ. Гэтэл тэнд тийм нөхцөл байдал байхгүй. Цас орно, хайлна гэж байхгүй. Цас ороод л хөлдөө, хунгарлаад, мөс болоод л байна. Дээрээс нь нар жаргахгүй. Байнга нар гарна. Тийм учраас дэглэм нь их өөр. Сая миний явсан үе бол Антарктид тивийн хамгийн дулаан цаг. Манайхаар бол долдугаар сар гэсэн үг. Өдөржин нар төөнөөд, шөнө дунд 03:00 цагаас хойш нар жаахан тонгойдог юм билээ. Би чинь гурван цагийн бүсийг дамжиж явсан. Монголоос Чилид, дараа нь Антарктидын бүсэд очсон. Сүүлдээ бүр учраа олохоо больсон. Нэлээд хэцүү байсан. Би эндээс явахынхаа өмнө “Винсон Массиф 4800-тай юм чинь би ямар ч байсан гарах л юм байна” гэж бодож явсан. Гэтэл үнэхээр чанга уул юм байна. Уул бол уул л юм байна гэж бодогдсон. Оргилын хяр дээр гарах үед маш их салхитай, хүйтэн байсан. Яг оргил дээр гарахад зураг авах боломж хэр байгаа бол гэж санаа зовж байлаа. Тэгээд яг оргил дээр нь гарахын өмнөхөн “За би Summter” болчихлоо шүү дээ гэж” бодогдсон шүү” хэмээсэн юм.

Б.Гангаамаа: Винсон Массиф дээр гарах үед “За би ингээд Summter” болчихлоо гэж бодогдсон

/ОУХМ, МУТТ/

Антарктид тивийн ноён оргил болох Винсон Массифын оройд гарч, дэлхийн долоон тивийн ноён оргилыг эзэлж, “Seven Summter” хэмээх түүхэн амжилтын эзэн болсон ОУХМ, МУТТ Б.Гангаамаа эх орондоо хүрэхэд ирнэхээ дараа мэдээлэл хийж, чөлөөт ярилцлага өрнүүлсэн билээ. Энэ үеэрээ тэрбээр “Би өнгөрсөн жил нэгдүгээр сарын дундуур Өмнөд Америкийн ноён оргил Аконкагуад гарч байлаа. Тэгвэл 2016 онд би дөрвөн том ноён оргилд гарч, “Seven Summter” хийж чадсан гайхалтай он байлаа. Хүмүүс дэлхийн таван оргил биш бил үү, долоо болчихсон юм уу гээд байдаг. Тэгвэл дэлхийд байгаа хуурай газрыг тооцвол долоон тив байдаг гэж үздэг. Үндсэн таван том тивээс гадна Австрали буюу арлын орнуудыг нэг тив гэж үздэг. Долоо дахь нь цагаан тив. Үндсэндээ мөсөн тив л дээ. Монголоос гараад Антарктидтай хил залган оршидог Чилийн Пунта-Аренас хотод очиход 3000 гаруй км зам туулж очсон. Үндсэндээ 4 цаг 50 минут нисч байж очсон. Оросын ИЛ-76 онгоцоор нисч очдог юм билээ. Гадна талаас нь харахад, том бүргэд шиг ч юм шиг том онгоц байсан. Тийм онгоцоор нисч очсон. Тэгээд л цаашаа Антарктид тивийн Олон улсын том лагерт очлоо. Тэнд жижиг онгоцны буудал байсан. Тэр том лагераас гурван чиглэл рүү

Дугаарын **60** мөр

Хүүхэд нийгмийн сүлжээний хохирогч биш

Үргэлжлэл. Түүрүү нь 1 нүүрт

Харин Монголын нийгмийн сүлжээ хэрэглэгчдийн тоо 1.3 сая. Цаашд ч энэ тоо өссөөр байх нь гарцаагүй. Хамгийн гол нь тэр дунд нүүрээ нуусан гэмт хэрэгтнүүд оршоор байна. Гэтэл социалд хэн байхаас үл хамааран аль нэг фэйсбүүк хаяг руу ороход л тухайн хүн хэн болох, юу сонирхож юугаар дутагдаж байгааг нь ядах юмгүй л ойлгоно. Бас гэр бүлтэй эсэх, үр хүүхэдтэй юу үгүй юу гэдгийг өөрийн социал хуудастаа юу постолж, юу хуваалцаж, мөн юу гэж сэтгэгдэл үлдээж байгаагаас л төвөггүйхэн мэдчихжэ байна. Зарим нь эхнэр нөхөртэйгөө хэрэлдэж муудалцсанаа, зарим нь хэн нэгэнд бухимдлаа илэрхийлэн хараалын үг урсгана. Харин зарим нь садар самуун бичлэг цацна. Нэг үгээр хэлбэл, ямар ч шүүлтүүргүй, хяналтгүй зүсэн зүйлийн хог нөвсхөн газарт сайтад нялх үрийнхээ зургийг нийтлэхэд аюулгүй гэсэн баталгаа байна уу. Нийгмийн сүлжээ хэрэглэгч нэг сая гаруй хүн дунд сайхан байсан учраас ахлах хөтөч маань хурдан буухыг сануулсан. Ингээд л оргил дээр дөнгөж гараад л буусан даа. Антарктид тивийн уур амьсгал маш их хуурай. Тэнд ямар ч чийг байхгүй. Яагаад гэвэл тэнд ногоон ургамал гэж байхгүй. Мөн бороо орж байж, эсвэл цас хайлж гэмээр чийгтэй болно шүү дээ. Гэтэл тэнд тийм нөхцөл байдал байхгүй. Цас орно, хайлна гэж байхгүй. Цас ороод л хөлдөө, хунгарлаад, мөс болоод л байна. Дээрээс нь нар жаргахгүй. Байнга нар гарна. Тийм учраас дэглэм нь их өөр. Сая миний явсан үе бол Антарктид тивийн хамгийн дулаан цаг. Манайхаар бол долдугаар сар гэсэн үг. Өдөржин нар төөнөөд, шөнө дунд 03:00 цагаас хойш нар жаахан тонгойдог юм билээ. Би чинь гурван цагийн бүсийг дамжиж явсан. Монголоос Чилид, дараа нь Антарктидын бүсэд очсон. Сүүлдээ бүр учраа олохоо больсон. Нэлээд хэцүү байсан. Би эндээс явахынхаа өмнө “Винсон Массиф 4800-тай юм чинь би ямар ч байсан гарах л юм байна” гэж бодож явсан. Гэтэл үнэхээр чанга уул юм байна. Уул бол уул л юм байна гэж бодогдсон. Оргилын хяр дээр гарах үед маш их салхитай, хүйтэн байсан. Яг оргил дээр гарахад зураг авах боломж хэр байгаа бол гэж санаа зовж байлаа. Тэгээд яг оргил дээр нь гарахын өмнөхөн “За би Summter” болчихлоо шүү дээ гэж” бодогдсон шүү” хэмээсэн юм.

Б.Энхбаяр: “Долоохон хоног ял эдэлж байсан юм” гэдэггүй, шоронд суусан л бол суусан

/Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд/
УИХ-аар Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг хэлэлцэж эхлээд байна. Уг төсөл нь УИХ-аас 2015 онд баталсан Эрүүгийн хуулийн (шинэчилсэн найруулга) төслөөс үзэл баримтлалын хувьд хэр өөрчлөгдсөн тухай Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд Б.Энхбаяр байр сууриа илэрхийлсэн. Тэрбээр “Эрүүгийн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн төсөл нь 2015 онд баталсан Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга)-ийн гол үзэл баримтлалаа хадгалсан гэж хэлж болно. Шинэ Эрүүгийн

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ



БМЖС-ын сайд Ж.Байтсууря

“
Аaаeéí òàì èð, òàì òòòóí òàèáàðóí
çàðàeüã ÁÍÁ-íeé 1.5 óóàüã
òçðàýííüð òòòàeí òeñ îðíü
òàèáàðò òààüæ áóé àí àeí àí
ÿì àð ààeáààã èëüðòeèeéæ, òüð
÷eíüÿäÿüðÿ àðà èðäÿäeéí ò
íü ÿðçè è ýíã, àeã äÿeäðóí
ò°áæèèéí òçàòeí à òí àí òòí èeáí á
”

ДЭЛХИЙ



Д.ТРАМПЫН НУУЦ БИЧЛЭГИЙГ

ГАРТАА ОРУУЛСАН УУ

Б.ДАВАА

Ойрхи Дорнодоод явуулж буй цэргийн ажиллагаа, Украины хамралтай холбоотойгоор АНУ, ОХУ-ын харилцаа хүйтэрсэн. Улмаар өнгөрсөн онд явагдсан Ерөнхийлөгчийн сонгуулийн дунд ОХУ-ын талаас нөлөөлсөн гэх мэдээллийг АНУ-ын Тагнуулын төв газраас мэдээлсний дараа Барак Обама нэр бүхий дипломатуудыг эх орон руу нь буцаах шийдвэр гаргасан юм. Гэвч ирэх долоо хоногт тангаргаа өргөх 45 дахь Ерөнхийлөгч Доналд Трамп сонгуулийн үр дүнд ОХУ нөлөөлөгүй хэмээж, АНУ-ын хамгийн хүчирхэг хүн болсныхоо дараа В.Путинтай ойртож, Ойрхи Дорнод дахь цэргийн ажиллагаанд ч хамтран ажиллахаа мэдэгдсэнээр хоёр улсын харилцаа ирээдүйд сайжрах төлөвтэй байгаа. Түүнчлэн, үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан эр өөрийн кабинетынхаа хамгийн чухал албан тушаал буюу Төрийн нарийн бичгийн даргын суудалд ч ОХУ-тай ойр харилцаатай гэгддэг "Ехон Мобил" компанийн гүйцэтгэх захирал Рекс

Тиллерсоныг нэрлэсэн билээ. Тэгвэл саяхан ОХУ АНУ-ын Ерөнхийлөгчийн маш нууц бичлэгийг гартаа оруулсан гэх мэдээлэл цацагдаж эхлэв. Оросын нэгэн тагнуул Доналд Трампын шударга бус үйлдэл, маш нууц хувийн чанартай болон санхүүгийн баримтыг гартаа оруулж авсан гэдгээ мэдэгдсэн байх юм. АНУ-ын Тагнуулын төв газраас ч уг явдлын талаар Трампд өөрт нь мэдэгдсэн аж. Харин тэрбумтан эр мэдээллийг хармагцаа "Хуурамч мэдээлэл байна" хэмээн эрс үгүйсгэсэн байна. Тодруулбал, энэ сарын 6-нд АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр явуулсан Оросын хакеруудын цахим дайралттай холбоотой баримтыг Тагнуулын төв газраас Доналд Трампд танилцуулсан. Тухайн үед шинэ Ерөнхийлөгчтэй холбоотой хоёр ч хуудас материал байсан гэнэ. Гэхдээ албаныхан улсын Ерөнхийлөгчийн нэр хүндтэй холбоотой учраас тус нууц мэдээллийн талаар дэлгэрэнгүй дамжуулаагүй. Гэхдээ Си Эн Эн агентлаг Их Британид төвтэй MI6 гэх байгууллагын тагнуулчаар ажиллаж байсан нэгэн

...Чухам эл бичлэгийг л Орос Трампыг өөрсдийн талд эргүүлэхдээ ашигласан байх магадлалтай тухай мөн дурьдсан байсан аж. Түүнчлэн, Оросын эрх баригчид Доналд Трампын бодлого, үйл хэрэгт нөлөөтэй оролцсоны зэрэгцээ их хэмжээний мөнгөн шилжүүлэг хийх гэрээ ч хийгдсэн гэх мэдээлэл байгаа юм...

эрхмийн нэгтгэсэн мэдээлэлд үндэслэн Д.Трампын хувийн нууц мэдээллийг ОХУ гартаа оруулсан талаар дамжуулсан байх юм. Нэрээ нууцалсан тэрхүү тагнуулч АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшигчдийн өрсөлдөгчдийн судалгааг өнгөрсөн жилийн зургадугаар сар хүртэл явуулсан аж. Ингэхэд Ерөнхийлөгчийн сонгуулийн үеэр Трампын тал болон ОХУ-ын Засгийн газар хооронд тогтмол мэдээлэл солилцоо явагдаж байсан гэнэ.

Харин Си Эн Эн агентлаг уг асуудлыг хөндсөний дараа Доналд Трамп ч няцаалт хийсэн. Тэрбээр өөрийн твиттер хуудастаа "Худал мэдээлэл" хэмээн үгүйсгэсэн юм. Нөгөөтэйгүүр, АНУ-ын "Buzzfeed" гэх мэдээллийн сайтад үнэн эсэх нь тодорхойгүй баримт дүгнэлт бүхий 35 хуудас тэмдэглэл нийтлэгдсэн байв. Түүнд Доналд Трамп 2013 онд ОХУ-ын нийслэл Москва хотод байрлах зочид буудалд хоноглох үедээ биеэ үнэлэгч худалдан авч, түүнтэйгээ дотно харилцаанд орж буйг нь бичсэн секс бичлэг ОХУ-ын гарт байгаа талаар дурьдсан байжээ. Чухам эл бичлэгийг л Орос Трампыг өөрсдийн талд эргүүлэхдээ ашигласан байх магадлалтай тухай мөн дурьдсан байсан аж. Түүнчлэн, Оросын эрх баригчид Доналд Трампын бодлого, үйл хэрэгт нөлөөтэй оролцсоны зэрэгцээ их хэмжээний мөнгөн шилжүүлэг хийх гэрээ ч хийгдсэн гэх мэдээлэл байгаа юм.

Тэгвэл энэ мэдээлэл цацагдаж эхэлсний дараа Доналд Трамп хэвлэлийн хурал хийсэн. Энэ үеэр анх удаагаа ОХУ-ын Засгийн газар АНУ-ын Ерөнхийлөгчийн сонгуульд саад хийхийг оролдсоныг хүлээн зөвшөөрсөн байгаа юм. Гэхдээ түүнтэй холбоотой нууц мэдээлэл Оросын гарт байгаа гэх асуудалд "Худал" гэх тайлбарыг өгчээ. Түүнчлэн, buzzfeed сайтад тавигдсан 35 хуудас бүхий мэдээлэл болоод CNN агентлагийн мэдээллийг "Хуурамч, урьдаас бэлдсэн худал гүтгэлэг" хэмээн уурсчээ.

А.В.Александровын ансамбль тоглолтонд бэлтгэж эхлэв

ОХУ-ын зэвсэгт хүчний А.В. Александровын нэрэмжит дуу бүжгийн чуулгынхан осолд өртсөн эмгэнэлт үйл явдал болсон билээ. Шинэ оны өмнөхөн Хар тэнгист осолдсон Ту-154 онгоцны ослоор 60 гаруй уран бүтээлчээ цаг бусаар алдсан. ОХУ-ын Батлан хамгаалах яамны Ту-154 онгоц арванхоёрдугаар сарын 25-нд осолдож, онгоцонд зорчиж явсан 84 хүн, нисэх багийн найман гишүүн бүгд амь үрэгдсэн. Тэдний 62 нь А.В.Александровын нэрэмжит цэргийн дуу, бүжгийн чуулгын уран бүтээлчид байсан билээ. Тэгвэл тус чуулгынхан эмгэнэлт ослоос хойшхи анхны тоглолтдоо бэлтгэж эхэлжээ. Хоёрдугаар сарын 23-нд тохиох Эх орончдын өдрөөр Кремльд

болох хүндэтгэлийн гала тоглолтод Улаан армийн дуу, бүжгийн чуулга уран бүтээлээ толилуулах ёстой учраас чуулгын удирдлага тоглолтын бэлтгэлийн зэрэгцээ амиа алдсан уран бүтээлчдийнхээ орон зайг нөхөж, бүрэн бүтэн болгохын тулд сонгон шалгаруулалт зарлаад байгаа аж. Сонгон шалгаруулалтыг нэгдүгээр сарын 16-наас эхлэн 10 хоногийн хугацаанд явуулах гэнэ. Мөн чуулгын уран сайхны найруулагч, удирдаач, дэслэгч-генерал Валерий Халиловын гэгээн дурсгалыг хүндэтгэж, Москвагийн цэргийн хөгжмийн сургуулийг Валерий Халиловын нэрэмжит болгохоор ОХУ-ын ерөнхий сайд Дмитрий Медведев шийдвэрлэжээ.

"Самсунг"-ийн дэд ерөнхийлөгчийг авлигын хэрэгт буруутган баривчилжээ

Өмнөд Солонгосын Прокурорын ерөнхий газраас Ерөнхийлөгч Пак Гын Хегийн авлигын дуулиантай холбогдуулан "Самсунг" группын өв залгамжлагч, Дэд ерөнхийлөгч Ли Жэ Ёнг баривчилсан талаар мэдээллээ.



Түүнийг авлигын хэрэгт холбогдуулан өчигдөр орон нутгийн цагаар 13:00 цагт баривчилж, байцаахаар болжээ. Ерөнхийлөгч Пак Гын Хегийн найз гэгдэх Чой Сүн Шил найзынхаа

нэр хүндийг ашиглан томоохон компаниудын удирдлагыг дарамталж, их хэмжээний хандив нэрийн дор авлига авдаг байсан хэмээн буруутгагдаж буй. Тэгвэл Ерөнхийлөгч болон түүний найзад их хэмжээний мөнгө хандивладаг байсан хандивлагчийн нэг нь Ли Жэ Ёнг гэнэ. Мөн тэрбээр Чой Сүн Шилийн охинд олон тэрбумын үнэтэй хурдны морь бэлэглэж байсан ажээ.

Хүчингүйд тооцов

-Мөнхбат овогтой Дорждэрэмийн 18641329494274 нэгж талбарын дугаартай 507м2 СБД-ийн 19-р хороо Баянбулагт байрлалтай зуслангын зориулалттай газар эзэмших эрхийн гэрчилгээ гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.

Зар Зар Зар

Цэнгэлдэхийн хажууг "Хург"-ын байранд 1 өрөө байр зарна

Утас: 96689101

УРИЛГА

БНХАУ-ЫН ТЯНЬЖИН БООМТЫН ДУНЗЯНЫ ЧӨЛӨӨТ ХУДАЛДААНЫ БООМТ БҮСЭД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТЭЭВЭР ЛОЖИСТИКИЙН ТӨСӨЛД ХАМТРАН АЖИЛЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын "Далайд гарах боломжийг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 2013 оны 152 дугаар тогтоолын хүрээнд БНХАУ-ын Тяньжин хотын Дунзян чөлөөт худалдааны боомт бүсийн 10 га газарт Хятадын талтай хамтарсан компани байгуулж "Тээвэр ложистикийн төв" төслийг хэрэгжүүлэх, энэхүү төсөлд хөрөнгө оруулж, хамтран ажиллах боломж бүхий дотоодын хувийн хэвшлийн аж ахуйн нэгжүүдийг хамтран ажиллахыг урьж байна.

Санал ирүүлэх компаниудад тавигдах шаардлага

- Компани татварын өргүй;
- Санхүүгийн чадамжтай;

-Тогтвортой, удаан хугацаанд хамтран ажиллах.

Санал авах хугацаа

Саналыг 2017 оны 2-р сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд "Монголын төмөр зам" ТӨХК-д албан бичгээр эсвэл baigalmaa@mtz.mn цахим хаягаар ирүүлнэ үү.

Хаяг:
"Монголын төмөр зам" Төрийн Өмчиг Хувьцаат Компани
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-23, УВН центр, 8-р давхар
Улаанбаатар 14230
Утас: (976) 99140072
Факс: (976) 70106644
Вебсайт: www.mtz.mn



-Японд өөрийнхөө төлсөн тэтгэврийн даатгалын шимтгэлийн талаарх мэдээлээ хэрхэн шалгах вэ?

-Японд тэтгэврийн даатгалын шимтгэл төлөгчид Японы Нийгмийн даатгалын Ерөнхий газрын өөрт ойр байрлах хэлтсүүдийн нэг цонхны үйлчилгээнээс, эсвэл холбогдох утас руу залгаж яриад л өөрсдийн төлсөн шимтгэлийн нийт дүн, төлсөн хугацаа зэрэг бүртгэлийн мэдээлээ шалгаж, хянах боломжтой байдаг. Түүнчлэн, Японы Нийгмийн даатгалын Ерөнхий газрын цахим хуудаст бүртгүүлж, шимтгэл төлөгчийн ID, нууц үгээ оруулаад л өөрсдийн тэтгэвэр тэтгэмжтэй холбоотой бүртгэлийн мэдээлээ шалгаж болно.

ЦАГ ҮЕ

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

“МЭДЭЭЛИЙН ХАРИЛЦААНЫ ТЕХНОЛОГИЙГ БАГШЛАХ БОЛОН СУРАХ ҮЙЛД НЭВТРҮҮЛЭХ ДАВЛАГААГ ЭХЛҮҮЛЖ ЧАДЛАА”

Ж.ОТГОН

Япон Улсын хамтын ажиллагааны Жайка байгууллага, Монгол Улсын БСШУСЯ, Японы Токиогийн технологийн сургууль, МУБИС хамтран “Хөдөөгийн бага боловсролын чанарыг ахиулахад мэдээллийн харилцааны технологийг оновчтой ашиглах нь” төслийг 2012-2017 онд хэрэгжүүлжээ. Энэхүү төслийн гол зорилго нь “Суралцахуйг дэмжих арга зүйг дэмжин хөгжүүлэх нь сургалтын чанарт нөлөөлж улмаар сурагчдын сурах үйл явцад нөлөөлөх” юм. Хөдөөгийн бага ангийн багш нарын мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор мэдээллийн харилцааны технологийг ашиглах, улмаар орон нутгийн дижитал сургалтын материал боловсруулсан сургалтдаа ашиглах үр чадварыг эзэмшүүлэх зорилготой уг төсөл амжилттай хэрэгжиж дууссан байна.



Төслийн талаар Токиогийн технологийн сургуулийн профессор Юмэ Ямагучи “Төсөлд хамтран ажилласан бүх хүнд баяр хүргэхийг хүсч байна. Энэ төсөл анх 2012 онд хэрэгжиж эхлэхэд ЖАИКА-гийн мэргэжилтэн Ивай энэ төсөл Монгол орон даяар шинэ давллага бий болгоно хэмээж байсныг би тодхон санаж байна. Өнөөдөр бид төслийн гишүүд, багш нар, сургуулийн удирдлагууд, мэргэжилтнүүд нар мэдээллийн харилцааны технологийг багшлах болон сурах үйлдээ нэвтрүүлж байгаагаар энэ давллага бий болгож чадсан гэдэгт итгэлтэй байна. Монгол орны боловсролын салбарт 1990-ээд онд бий болсон шилжилтийн үр дүнд сургуулиуд мөнхүндэртэй тэр үеийг даван туулж байсан тэр өдрүүдэд багш нар Монгол орны өнцөг булан бүрт өндөр хөгжилтэй технологи ашиглан чанарын өндөр хэмжээнд өөрсдийн сургалтын материалаа бэлтгэх сайхан өдөр ирнэ гэдэгт итгэл дүүрэн байсан юм. Итгэл нь биелэл болоход энэхүү төслийн үйл ажиллагаа, үр дүн багш нарыг улам зоригжуулсан. Цаашид Монгол орны боловсролын байгууллага, сургуультай үргэлжлүүлэн хамтран ажиллах чин хүсэлтэй байгаагаа үүгээр уламжилж байна. Багш хүний хувьд миний сурган хүмүүжүүлэх хөдөлмөрийн түүхийн хамгийн дурсамжтай мөчүүд Монголын багш нартай хамт байсан шүү” хэмээв. Төслийн талаар МУБИС-ийн Сургалт, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал, доктор профессор Х.Тамир “МУБИС маань Токиогийн технологийн сургуультай хамтарч энэхүү төслийг 2012-2017 оны хугацаанд хэрэгжүүлээд өнөөдөр хаалтаа хийж байна. Төслийн хугацаанд нэлээд олон DVD-гээр видео хичээлүүдийг багш нар өөрсдөө боловсруулсан. Өөрөөр хэлбэл, эндээс арга зүйн зөвлөмжийг нь өгчиглүүдэд, багш нар өөрсдөө

харилцааны технологийг ашиглах, улмаар орон нутгийн дижитал сургалтын материал боловсруулсан сургалтдаа ашиглах үр чадварыг эзэмшүүлэх зорилготой уг төсөл амжилттай хэрэгжиж дууссан байна. Төслийн талаар Токиогийн технологийн сургуулийн профессор Юмэ Ямагучи “Төсөлд хамтран ажилласан бүх хүнд баяр хүргэхийг хүсч байна. Энэ төсөл анх 2012 онд хэрэгжиж эхлэхэд ЖАИКА-гийн мэргэжилтэн Ивай энэ төсөл Монгол орон даяар шинэ давллага бий болгоно хэмээж байсныг би тодхон санаж байна. Өнөөдөр бид төслийн гишүүд, багш нар, сургуулийн удирдлагууд, мэргэжилтнүүд нар мэдээллийн харилцааны технологийг багшлах болон сурах үйлдээ нэвтрүүлж байгаагаар энэ давллага бий болгож чадсан гэдэгт итгэлтэй байна. Монгол орны боловсролын салбарт 1990-ээд онд бий болсон шилжилтийн үр дүнд сургуулиуд мөнхүндэртэй тэр үеийг даван туулж байсан тэр өдрүүдэд багш нар Монгол орны өнцөг булан бүрт өндөр хөгжилтэй технологи ашиглан чанарын өндөр хэмжээнд өөрсдийн сургалтын материалаа бэлтгэх сайхан өдөр ирнэ гэдэгт итгэл дүүрэн байсан юм. Итгэл нь биелэл болоход энэхүү төслийн үйл ажиллагаа, үр дүн багш нарыг улам зоригжуулсан. Цаашид Монгол орны боловсролын байгууллага, сургуультай үргэлжлүүлэн хамтран ажиллах чин хүсэлтэй байгаагаа үүгээр уламжилж байна. Багш хүний хувьд миний сурган хүмүүжүүлэх хөдөлмөрийн түүхийн хамгийн дурсамжтай мөчүүд Монголын багш нартай хамт байсан шүү” хэмээв. Төслийн талаар МУБИС-ийн Сургалт, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал, доктор профессор Х.Тамир “МУБИС маань Токиогийн технологийн сургуультай хамтарч энэхүү төслийг 2012-2017 оны хугацаанд хэрэгжүүлээд өнөөдөр хаалтаа хийж байна. Төслийн хугацаанд нэлээд олон DVD-гээр видео хичээлүүдийг багш нар өөрсдөө боловсруулсан. Өөрөөр хэлбэл, эндээс арга зүйн зөвлөмжийг нь өгчиглүүдэд, багш нар өөрсдөө

харилцааны технологийг ашиглах, улмаар орон нутгийн дижитал сургалтын материал боловсруулсан сургалтдаа ашиглах үр чадварыг эзэмшүүлэх зорилготой уг төсөл амжилттай хэрэгжиж дууссан байна. Төслийн талаар Токиогийн технологийн сургуулийн профессор Юмэ Ямагучи “Төсөлд хамтран ажилласан бүх хүнд баяр хүргэхийг хүсч байна. Энэ төсөл анх 2012 онд хэрэгжиж эхлэхэд ЖАИКА-гийн мэргэжилтэн Ивай энэ төсөл Монгол орон даяар шинэ давллага бий болгоно хэмээж байсныг би тодхон санаж байна. Өнөөдөр бид төслийн гишүүд, багш нар, сургуулийн удирдлагууд, мэргэжилтнүүд нар мэдээллийн харилцааны технологийг багшлах болон сурах үйлдээ нэвтрүүлж байгаагаар энэ давллага бий болгож чадсан гэдэгт итгэлтэй байна. Монгол орны боловсролын салбарт 1990-ээд онд бий болсон шилжилтийн үр дүнд сургуулиуд мөнхүндэртэй тэр үеийг даван туулж байсан тэр өдрүүдэд багш нар Монгол орны өнцөг булан бүрт өндөр хөгжилтэй технологи ашиглан чанарын өндөр хэмжээнд өөрсдийн сургалтын материалаа бэлтгэх сайхан өдөр ирнэ гэдэгт итгэл дүүрэн байсан юм. Итгэл нь биелэл болоход энэхүү төслийн үйл ажиллагаа, үр дүн багш нарыг улам зоригжуулсан. Цаашид Монгол орны боловсролын байгууллага, сургуультай үргэлжлүүлэн хамтран ажиллах чин хүсэлтэй байгаагаа үүгээр уламжилж байна. Багш хүний хувьд миний сурган хүмүүжүүлэх хөдөлмөрийн түүхийн хамгийн дурсамжтай мөчүүд Монголын багш нартай хамт байсан шүү” хэмээв. Төслийн талаар МУБИС-ийн Сургалт, хамтын ажиллагаа эрхэлсэн дэд захирал, доктор профессор Х.Тамир “МУБИС маань Токиогийн технологийн сургуультай хамтарч энэхүү төслийг 2012-2017 оны хугацаанд хэрэгжүүлээд өнөөдөр хаалтаа хийж байна. Төслийн хугацаанд нэлээд олон DVD-гээр видео хичээлүүдийг багш нар өөрсдөө боловсруулсан. Өөрөөр хэлбэл, эндээс арга зүйн зөвлөмжийг нь өгчиглүүдэд, багш нар өөрсдөө



ОРХОН АЙМАГ

Улсын аварга малчин, тариаланчид нэр дэвших иргэн, ААН-ийн нэрс тодров

Орхон аймгийн Засаг даргын зөвлөл энэ сарын 11-нд хуралдаж, Улсын аварга малчин, фермер, тариаланч, тариаланч хамт олноор шалгаруулж, Хүнс, хөдөө аж ахуйн нэгжийн нэрсийг тодрууллаа. Урьд жилүүдэд дээрх шалгаруулалтыг явуулахдаа “Улсын тэргүүний” тодотголоор олгохоос гадна сүүлийн хоёр жилийн ажлын үзүүлэлтийг харгалзаж үздэг байсан. Тэгвэл Засгийн газрын 2016 оны арванхоёрдугаар сарын 21-ний өдрийн 202 дугаар тогтоолоор шалгаруулалт явуулах журамд өөрчлөлт орж, тодотголыг “Улсын аварга” болгон өөрчилж, сүүлийн гурван жилийн ажлын үзүүлэлтээр шалгаруулахаар болсон аж. Үүний дагуу Засаг даргын зөвлөлөөс Баян-Өндөр, Жаргалант сумаас Улсын аварга малчин төрөлд нэг, фермер төрөлд нэг, тэргүүний тариаланч аж ахуйн нэгж төрөлд хоёр байгууллага, тэргүүний тариаланч иргэн төрөлд нэг иргэнийг тодруулах шийдвэр гаргажээ. Тодруулбал, “Улсын аварга малчин”-аар Баян-Өндөр сумын Говил багийн малчин С.Баасандорж шалгарлаа. Тэрбээр мал аж ахуйн салбарт 21 жил үр бүтээлтэй ажилласан. Өнгөрсөн оны эцэст 770 орчим толгой мал тоолуулснаас гадна “галшир”, “сэлэнгэ”, “барга”, “эрчим” үүлдрийн эцэг малаар мал сүргийнхээ угсааг сайжруулж байгаа аж.

Тэгвэл Улсын аварга фермерээр Баян-Өндөр сумын Говил багийн иргэн Б.Баттөр тодорлоо. Б.Баттөр нь анх 2009 онд сүүний үхрийн аж ахуй эрхэлж эхэлсэн бөгөөд 2014 онд сүүний фермер болгон өргөжүүлсэн байна. Анх 60 үнээтэй үйл ажиллагаагаа эхлүүлсэн бол эдүгээ 160 орчим үхэртэй болж нэг үнээний дундаж саамыг жилд 410 литр хүргэсэн амжилттай ажиллаж байгаа нэгэн аж. Мөн Улсын аварга тариаланч хамт олноор өнгөрсөн онд 1250 га талбайд тариалалт хийж га-аас 40.3 цн ургац хураан авсан “Бүтлийн ундарга” болон өнгөрсөн онд 620 га талбайд тариалалт хийж га-с 31.9 тонн ургац хураан авсан “Орхон тариа” ХХК тодруулах шийдвэр гаргалаа. 2016 онд “Бүтлийн ундарга” ХХК татварт 23.2 сая орчим, нийгмийн даатгалд 27 орчим сая төгрөг, “Орхон тариа” ХХК татварт 19.4 сая, нийгмийн даатгалд 16.58 сая төгрөгийг тус тус төвлөрүүлсэн аж. Түүнчлэн Улсын аварга тариаланчаар Баян-Өндөр сумын Шанд багийн тариаланч М.Цогтгэрэл, Жаргалант сумын Улаантолгой багийн тариаланч Ч.Баяртөгтох, “Орхон тариа” ХХК-ийн тракторч, комбайнч Л.Отгонбаяр нарыг шалгаруулах шийдвэрийг Засаг даргын зөвлөлийн гишүүд гаргалаа. Ингэснээр дээрх иргэн, ААН-ийн нэрсийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэхээр боллоо. Хэрэв эдгээр иргэн, ААН нь тус яамнаас дэмжигдвэл Засгийн газрын хуралдаанаар эцсийн шийдвэр гарах юм байна.

БУЛГАН АЙМАГ

Цэцэг өвчнөөс сэргийлэх талаар хамтарсан сургалт, сургуулилт хийлээ

Булган аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Хөвсгөл аймгийн МХГ-тай хамтран Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Гуртын гүүрний Мал эмнэлэг хорио цэрийн шалган нэвтрүүлэх хяналтын хэсэгт малын хил дээр очих замууд нэгдэж өвчнөөс урьдчилан сэргийлэх мэдээлэл сургалт, үйл ажиллагааг зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд Булган, Хөвсгөл аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга нар, улсын байцаагчид, Хөвсгөл аймгийн ХХАА-н газрын Мал багатай салбар хаана байгаа зэргийг мэдэх боломжтой. Үүнээс гадна улс, хот хоорондын ачаа, зорчигч, жуулчин тээвэр, авто үйлчилгээ, мэргэшсэн жолооч, тээврийн хэрэгслийн татвар, даатгалтай холбоотой бүхий л мэдээллийг нэг дор хүлээн авч болно. Нийт дуудлагаа ажиглаад үзвэл ихэнх тохиолдлыг зам гарц хаасан дуудлага ирдэг. Цаашид ямар арга хэмжээ авах вэ. Тусгай дугаарын утасны ачаалал нэмэгдсэн гэж хэллээ. Тэгэхээр хийх ажил олон байгаа байх? -Эр нь манай дуудлагын ачаалал маш их байдаг. Тиймээс лавлах шугамны тоог өргөтгөх ажлыг төлөвлөж байна. Нэг үгээр хэлбэл, лавлагаа өгч байгаа мэргэжилтнүүдийн тоог олон болгох юм. Мөн авто вокзал руу явах, интернэтэд холбогдох боломжгүй хэрнээ тасалбар захиалах хүсэлтэй хүмүүс байж болно шүү дээ. Ийм бүхий л мэдээллийг нэг дор хүлээн авч болно. Нийт дуудлагаа ажиглаад үзвэл ихэнх тохиолдлыг зам гарц хаасан дуудлага ирдэг. Цаашид ямар арга хэмжээ

ӨДРИЙН СУРВАЛЖЛАГА

1900-1234 дугаар таны дотны туслах болж чадна

Үргэлжлэл. Түүрүүч нь I нүүрт

Ингэснээр ах, дүү, хамаатан садан, үр хүүхдээ хаана явж байгаа, аюулгүй эсэхийг мэдэх боломжтой юм байна. Энэ мэтчилэн олон үйлчилгээг иргэдэд үзүүлэх болжээ. Үйлчилгээний төрөл нэмэгдэхийн хэрээр лавлах утсанд хандах иргэдийн тоо нэмэгдсэн гэнэ. Энэ талаар лавлах үйлчилгээний ажилтан Д.Үүрийнтуяа “Манай 1900-1234 тусгай дугаарын утсанд хандаж буй дуудлагын дийлэнх хувийг гарц хааж зогссон тээврийн хэрэгслийн эзэмшигчтэй холбогдох дуудлага эзэлдэг. Иргэд ихэвчлэн улс, хот

хоорондын зорчигч тээврийн байршил, тасалбар захиалгын үйлчилгээ авч байна. Мөн татвар, даатгал, архив лавлагааг авдаг” гэв.

Ингээд бид Автотээврийн үндэсний төвийн Хөдөлгөөний хяналтын хэлтсийн ахлах тэргэжилтэн Б.Мөнхчулуунтай цөөн хором ярилцлаа.

-1900-1234 тусгай дугаарын утас ажиллаад нэг жил болж байна. Энэ хугацаанд иргэдэд аль хэдийнэ танигдсан. Тэгэхээр өнгөрсөн хугацаанд дахь ажлаа дүтнээд ярьвал? Манай Автотээврийн үндэсний төв ард иргэдэд авто



тээвэртэй холбоотой мэдээ, мэдээллийг түргэн шуурхай үнэн бодитойгоор хүргэх зорилгоор

автотээврийн нэгдсэн лавлах 1900-1234 тусгай дугаарын утсыг ажиллуулаад нэг жил болж байна. Ер нь сар болгоны мэдээг аваад үзэхэд манай дуудлагын хэмжээ байнгын өсөлттэй гарч байгаа. Энэ нь манай лавлах төвөөс өгч байгаа мэдээлэл ард иргэдэд хүрч байгаагийн нэг илрэл болов уу хэмээн бид харж байна.


-Иргэд тусгай дугаарын утаснаас ямар үйлчилгээг авах боломжтой вэ?

-Манай тусгай дугаарын лавлах утаснаас иргэд хэд хэдэн үйлчилгээг авах боломжтой. Тухайлбал, тээврийн хэрэгслийн бүртгэл, улсын дугаар солих, шилжилт хөдөлгөөн бүртгүүлэх, хасуулах, лавлагаа авах, явуулын

дугаар олгох, цагийн хуваарь, байршил, үнэ тариф, бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт, мөн техникийн хяналтын үзлэгт үзлэгтэй холбоотой мэдээлэл, техникийн хяналтын үзлэгт орох цаг захиалах, хэрэглэгчийн байршилд тохирсон ачаалал багатай салбар хаана байгаа зэргийг мэдэх боломжтой. Үүнээс гадна улс, хот хоорондын ачаа, зорчигч, жуулчин тээвэр, авто үйлчилгээ, мэргэшсэн жолооч, тээврийн хэрэгслийн татвар, даатгалтай холбоотой бүхий л мэдээллийг нэг дор хүлээн авч болно. Нийт дуудлагаа ажиглаад үзвэл ихэнх тохиолдлыг зам гарц хаасан дуудлага ирдэг. Цаашид ямар арга хэмжээ

авах вэ. Тусгай дугаарын утасны ачаалал нэмэгдсэн гэж хэллээ. Тэгэхээр хийх ажил олон байгаа байх? -Эр нь манай дуудлагын ачаалал маш их байдаг. Тиймээс лавлах шугамны тоог өргөтгөх ажлыг төлөвлөж байна. Нэг үгээр хэлбэл, лавлагаа өгч байгаа мэргэжилтнүүдийн тоог олон болгох юм. Мөн авто вокзал руу явах, интернэтэд холбогдох боломжгүй хэрнээ тасалбар захиалах хүсэлтэй хүмүүс байж болно шүү дээ. Ийм бүхий л мэдээллийг нэг дор хүлээн авч болно. Нийт дуудлагаа ажиглаад үзвэл ихэнх тохиолдлыг зам гарц хаасан дуудлага ирдэг. Цаашид ямар арга хэмжээ

СПОРТ



БОКСЫН УАШТ-ИЙ МЕДАЛИЙН ТӨЛӨӨХ ТОГЛОЛТУУД ЭХЭЛЛЭЭ

Н.БОЛЦ

XX зууны манлай, гавьяат дасгалжуулагч Вандуйн Батбаярын нэрэмжит сонирхогчдын боксын насанд хүрэгчдийн УАШТ Спортын төв ордны "А" танхимд үргэлжилж байна. Эрэгтэйчүүдийн 37, эмэгтэйчүүдийн 13 дахь удаагийн тус тэмцээнд 39 багийн нийт 201 тамирчин эрэгтэй ес, эмэгтэй найман жинд өрсөлдөж буй. Тэгвэл өчигдөр хүрэл медалийн төлөөх тулаанууд болсон юм.

Заримаас нь онцолбол, 60 кг-ын жинд Монголын шилдэг тамирчин Д.Отгондалай Баянгол дүүргийн тамирчин Д.Түвшинтөгөлдөрийг техникийн илт давуу байдлаар ялж, хүрэл медалийн болзол хангалаа. Энэ жинд "Хангарьд" клубын тамирчин Д.Пүрэвсүрэн, "УБ Про" клубын тамирчин О.Батхүү, "Сүлд" спорт хорооны тамирчин Э.Цэндбаатар нарын шилдгүүд үлдээд байна. Тэгвэл 56 кг-ын жинд Х.Энх-Амар, В.Төмөрхуяг, Б.Төгөлдөр,

Б.Мишээлт нарын тамирчид медалийн болзол хангалаа. Энэ жингийн шилдгүүдээс Э.Цэндбаатар жин өгссөн бол Э.Идэрхүү улсын аваргыг өнжсөн. 52 кг-ын жинд хагас шигшээд А.Нурлан, Т.Энхтөр, Ц.Батнасан, М.Гандулам гэсэн дөрвөн тамирчин үлдээд байна. Өнөөдөр зарим жингийн хүрэл медалийн төлөөх тоглолтууд болох учиртай. Харин амралтын өдрүүдээр улсын аваргууд тодорно.

Шүүгчийн ЗЭРЭГ ОЛГОХ ШАЛГАЛТЫГ өнөөдөр зохион байгуулна



Монголын туялзуур сэлэмний холбооны 2017 оны анхны арга хэмжээ болох шүүгчдийн II семинар, шүүгчийн зэрэг олгох шалгалтыг өнөөдөр зохион байгуулах ажээ. Энэ нь дотоодын тэмцээнийг шүүх болон олон улсын шүүгчийн шалгалтад орох эрхийг олгох шалгалт гэсэн үг. Семинар, шалгалтад дөрвөн клубын 20 гаруй шүүгч оролцохоор бүртгүүлжээ. Сургалт, шалгаруулалт МҮОХ-ны хурлын танхимд болно. Монголын туялзуур сэлэмний холбооны шүүгч А.Халиунаа, Б.Цолмон нар 2016 онд Азийн зэрэглэлийн шүүгч болсон билээ.

ӨСВӨРИЙН ШАТАРЧДЫН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН БОЛНО

Өсвөрийн шатарчдын 2017 оны улсын аварга шалгаруулах тэмцээн нэгдүгээр сарын 18-22-ны хооронд МҮЭСТО-д болох ажээ. Тэмцээн 6-18 насны ангиллаар явагдана. Бүртгэл Монголын үндэсний олимпын хорооны 204 тоотод энэ сарын

16-17-ны өдрүүдэд үргэлжлэх юм байна. 2016 оны Өсвөрийн шатарчдын улсын аварга шалгаруулах тэмцээнд багийн дүнгээр эхний гурван байр эзэлсэн орон нутгийн багууд нэмэлт тоглогч оролцуулах боломжийг холбооноос олгосон байна.

Гимнастикчид хамтарсан бэлтгэл хийжээ

Монголын Гимнастикийн холбооны спортын гимнастикийн эрэгтэй, эмэгтэй баг тамирчид ОХУ-ын "Благовешенск" хотноо нэгдүгээр сарын 11-12-нд хамтарсан бэлтгэл хийсэн байна. Тэд өнөөдөр эхлэх "Благовешенск" хотын захирагчийн нэрэмжит олон улсын тэмцээнд оролцохын өмнө ийн хамтарсан бэлтгэл хийсэн ажээ. Энэхүү тэмцээнд Монгол, Филиппин, ОХУ-ын Владивосток, Благовешенск, Чита, Хабаровск, Райчихинск, Сахалин, Белогорск,

Комсомольск, Биробиджан, Якутск нийт 14 багийн 100 гаруй тамирчид өсвөр нас, насанд хүрэгчдийн ангиллаар оролцох юм байна. "Благовешенск" хотын нэрэмжит тэмцээнд Монголын хоёр дасгалжуулагч, 10 тамирчин оролцох юм байна. Эрэгтэй багийн дасгалжуулагч багш Ц.Алтантөгс, эмэгтэй, эрэгтэй багийн дасгалжуулагчаар Д.Оюунтуяа нар ажиллаж байгаа ажээ. Тэмцээн энэ сарын 15-нд өндөрлөх юм байна.

Жүдогийн улсын аваргыг Олимпын зэрэглэлийн шүүгчид ДЭНСЭЛНЭ

Боксын улсын аварга шалгаруулах тэмцээн өндөрлөсний дараа жүдо бөхийн УАШТ эхлэх учиртай. Тэгвэл шинэчлэгдсэн дүрмээр болох энэхүү тэмцээнийг Олимпын зэрэглэлийн шүүгчид дэнслэх юм байна. Тодруулбал, IJF-ийн шүүгч, Олимпын зэрэглэлийн шүүгч Чех улсын иргэн Владимир Хнедка, ОХУ-ын олимпын зэрэглэлийн шүүгч Владимир Востриков нар уригдан ажиллаж байгаа ажээ. Владимир Хнедка 2017 оны улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдад болон багш, дасгалжуулагч нарт IJF-ийн шинэ батлагдсан дүрмийг өнгөрсөн лхагва гарагт бэлтгэлийн үеэр танилцуулсан байна. Харин өнөөдөр Спортын төв ордонд 10:00 цагаас манай улсын шүүгчдэд IJF-ийн дүрмийн талаар сургалт явуулах ажээ.

Т.Орхон:

Н.ПУНЦАГБОЛЦ

58 кг-ын жинд дэлхийн суут бөх Японы тамирчин Каори Ичог ялж шуугиан тарьж явсан. Жин өгсч, 63 кг-д барилдаад, энэ жилийн улсын аваргаар дэлхийн хошой аварга, Олимпын хүрэл медальт С.Батцэцэгийг ялж түрүүлж, дахин шуугиан тариад байгаа П.Орхоныг энэ удаагийн дугаартаа урьж, ярилцлаа.

-Улсын аварга шалгаруулах тэмцээнд жин өгсч оролцож, С.Батцэцэг гавьяатыг ялж, түрүүлээ. Яагаад жин өгсч барилдахаар шийдэв?

-Өөрийнхөө байгаа жинд л тааруулж улсын аваргад оролцож байгаа юм. Олон кг хаяж, жин хасахгүй байга гэж шийдсэн. Өнгөрсөн жил 58 руу орох гэж олон кг хасч, цөөнгүй тэмцээнд оролцсон. Сүүлдээ Олимпын наадмын үеэр ядралт их авсан, сэргэж амжаагүй. Тэр алдаагаа давахгүйн тулд, нөгөө талаар байгаа жиндээ л оролцож гэж шийдээд 63 кг-д барилдчихлаа. Мэдээж энэ жингийн гол өрсөлдөгч, дэлхийд нэртэй тамирчин С.Батцэцэг эгчтэйгээ финалд таарсан. Ямар ч байсан чадах чинээгээр барилдана гэж дэвжээнд гарсан. Амжилттай барилдаж, ялж, улсын аварга болж чадсандаа баяртай байгаа.

-Мэдээж С.Батцэцэг гавьяаттай финалдана гэж тооцож барилдааныхаа тактикийг боловсруулсан байх?

-Би 63 кг-д хоёр дахь тэмцээндээ оролцсон нь улсын аварга. Оны өмнө гадагшаа явж нэг тэмцээнд оролцоод ирсэн. Жиндээ дасах зорилгоор явсан. Гэхдээ нэг их олон тойрог барилдаж чадаагүй. Тийм болохоор сая улсын аваргад оролцохдоо барилдаан бүртээ анхаарлаа дээд зэргээр төвлөрүүлж барилдсан. Шинэ жинд оролцож, барилдаж байгаагүй хүмүүстэй барилдсан болохоор хянуур байхгүй бол болохгүй шүү дээ. Мэдээж үдээс хойшийн барилдаан хамгийн чухал нь байлаа. Багш нартайгаа ч зөвлөлдсөн байсан. Тэр дагуу л барилдаад ялсан.

-Хамгийн гол нь тэр мундаг бөхийг оноогоор цэвэр ялсан шүү дээ. С.Батцэцэг гавьяат бэлтгэл жаахан тааруу байв уу. Эсвэл багш нарын чинь боловсруулсан тактик 100 хувь биелчихэв үү?

-Аль аль нь л таарсан байх. С.Батцэцэг гавьяатын бэлтгэл ч жаахан муу байсан болов уу. Бидний боловсруулсан, төлөвлөсөн тактик ч сайхан таарсан гэж бодож байна. Хоёр талаасаа л таарчихлаа.

-Одоо цаашид 63 кг-д барилдаж, олон улсын тэмцээнд оролцож гэж бодож байна уу?

-Тэгнэ. Нэгдүгээр сарын сүүлчээр Орост Иван Ярыгины "Алтан гран" при тэмцээн болно. Тэр тэмцээнд оролцох гээд л бэлтгэлээ хийгээд байна. Тэнд л шинэ жингийнхээ шилдэг бөхчүүдтэй барилдаж үзнэ дээ. Энэ тэмцээн бол зэрэглэл өндөртэй, өрсөлдөгч ихтэй болдог, шалгуур сайтай барилдаан. Тэгээд ч Оросын 63 кг-д шилдэг бөхчүүд олон бий. Олимпын наадамд тавдугаар байрт шалгарсан бөх ч байгаа. Тэдэнтэй л барилдаж үзэж, өөрийнхөө бэлтгэл, чадварыг шалгана даа.

-63 кг руу жин өгсөхөөр С.Батцэцэг гавьяаттай л өрсөлдөх нь. Энэ шилдэг бөхийн нас залуу байна, ур чадвар сайтай. Тийм болохоор нэг жинд хоёр шилдэг бөх чихээлдээ, нэг нь дарагдаад үлдэх юм биш биз дээ гэсэн бодол төрөөд байна?

-Мэдээж жин өгсч байгаа болохоор энэ шилдэг бөхтэй л өрсөлдөж таарна. Дотоодын уралдаан, тэмцээнд хүртэл. Ирэх зургадугаар сард дэлхийн аваргын урьдчилсан сорилго тэмцээн болно. Түүнээс өмнө ч гэсэн нэлээд хэдэн тэмцээн бий. Тэр болгонд оролцож, бэлтгэл сургуулилтаа илүү сайн хийнэ дээ. Ер нь бол олон улсын тэмцээнүүдэд оролцох боломж нээлттэй. Иван Ярыгины "Алтан гран при" тэмцээнд оролцож гэвэл хүссэн хүн


болгон явж болно. С.Батцэцэг эгч бид хоёр хоёулаа ч оролцох боломжтой. Харин дэлхийн аварга, Олимпын наадам гээд том тэмцээнд нэг тамирчин л явна. Гэхдээ нэг жинд өрсөлдөөн ихтэй, өрсөлдөгч сайтай байна гэдэг чинь ашигтай. Өрсөлдөөн ихтэй жингээс л амжилт гарна гэж би боддог. Тиймдээ ч хамгийн өрсөлдөөн ихтэй жинг сонгоод л орчихлоо. Миний хувьд тэрэнд ялагдчихвал яана аа, энийг хожихгүй бол гадагшаа явж чадахгүй нь гэж бодохгүй байгаа. Хамгийн гол нь өөртөө итгэх хэрэгтэй. Өөрийнхөө бэлтгэлийг урьд өмнөхөөсөө илүү сайн хийгээд явахад болох байх. Тэгээд С.Батцэцэг эгч бид хоёр бараг л насны зөрүүгүй. Надаас гурван насны л эгч байх. Ер нь бүх жинд л 2-3 сайн тамирчин байгаа. Хэн илүү бэлтгэлээ сайн хийж, өөрийгөө дайчилж чадсан нь улсаа төлөөлөд том тэмцээнд явна. Хамгийн гол нь дотооддоо л өрсөлдөөн сайн байх хэрэгтэй. Би Олимпын жин сонгоод орсон. Эцсийн зорилго Токюогийн Олимпын наадам. Би явж чадахгүй бол яана аа гэсэн бодол надад байхгүй. Өөрөө л сайн хичээж, өөртөө итгэх хэрэгтэй гэж бодож байна.

-Энэ жил ямар тэмцээнүүдэд оролцохоор төлөвлөж байгаа вэ?

-Энэ сард Орос руу "Алтан гран при"-д явна. Мөн Азийн аваргад оролцох бодол байгаа. Түүнээс өөрөөр төлөвлөсөн зүйл алга л байна. Багш нартайгаа ярилцана. Хэдэн сард ямар тэмцээн болохоор байх нь уу. Аль үед нь өндөр ачаалал авах нь зөв юм. Тэр болгоныг зохицуулж байж л тэмцээнд явна. Харин зургадугаар сард дэлхийн аваргын сорилтод орно. Тэндээс хэн нь эрхээ авсан нь дэлхийн аварга шалгаруулах тэмцээндээ бэлтгэнэ дээ.

-Ур чадварын хувьд хэнээс ч дутахааргүй сайн бөх гараад ирлээ. Шилдгүүдийг ялж чадаж байна. Гэхдээ дэлхийн аварга болох, цаашлаад түүнээс өндөр амжилт гаргахын тулд чухам юу дутуу байна гэж боддог вэ?

-Техник тактик, хүчний бэлтгэлжилт, ерөнхий бэлтгэл гээд бүгдийг нь Энхтөр, Хосоо, Цогоо багш нар маань хоорондоо яришдаг байгаад л хийлгэдэг. Тийм болохоор гурван багийнхаа удирдлага дор бэлтгэлээ хийгээд явж байхад хүнээс дутна гэж бодохгүй байгаа. Дэлхийн аваргад барилдах эрхээ авчихлаа гэж бодоход



СПОРТ



ӨРСӨЛДӨӨН ИХТЭЙ ЖИНГИЙН ТАМИРЧДААС Л ӨНДӨР АМЖИЛТ ГАРНА, ТИЙМДЭЭ Ч БИ 63 КГ-ЫГ СОНГОСОН



...Ар гэртээ анхаарч, гэр бүлээ аваад явж байгаа өч төчнөөн тамирчин байгаа. Өөр ямар нэг ажил хийдэггүй. Гол ажил нь тэмцээн уралдаанд оролцох байдаг. Гэтэл тамирчдын цалин мөнгө үнэхээр бага. Ар гэрээ авч явах хэмжээний биш. Тэглээ гээд яах вэ дээ, дуртай, сэтгэл зүрхээ зориулчихсан юм болохоор уйгагүй зүтгэдэг өчнөөн олон тамирчин байгаа...



бэлтгэлийг маань хангалттай зохицуулаад өгчихнэ гэдэгт багш нартаа итгэдэг. Надад бүх нөөц боломж гээд бүхий л зүйл байна. Дээрээс нь 63 кг-д барилдаж байгаагүй болохоор надаас илүү надтай барилдах хүмүүст эвгүй өрсөлдөгч болж болно шүү дээ.

Нэг шигшээд хамт барилддаг болохоор С.Батцэцэг гавьяагаас их зүйлийг суралцдаг байх. Чухам ямар чадварыг илүү их харж, суралцахыг эрмэлздэг вэ?

Шигшээ багийн эгч нар маань надад маш их тусалдаг. Бэлтгэл хийх үеэр өөрийнхөө мэддэг, чаддаг бүхнээ зааж өгдөг. Хүн хүнд л өөр өөрийн онцлог байдаг. Хурдаар, хүчээр, эвээр барилддаг

гээд тамирчин болгон ялгаатай. Тийм болохоор өөрийнхөө барилдаанд хамгийн хэрэгтэй гэснийг нь олж харахыг хичээдэг. Мөн тэр болгоныг нь асуугаад, зөвлөөд, суралцаад явдаг. С.Батцэцэг эгчийн хувьд маш тайван, барилдаандаа төвлөрч чаддаг. Оноо алдсан ч, хожигдож байсан ч тайван, өөрийнхөөрөө байж чаддаг. Намайг тэр чанараараа төстэй гэж багш нар мань хэлдэг. Би ямар ч тэмцээнд оролцохдоо ялагдаж явсан ч гэсэн

дуусч байна даа гэж боддоггүй. Дандаа л боломж байгаа гэж бодож барилддаг.

Одоо 63 кг-д шинэ залуу шилдэг тамирчид гарч ирж байна. Та хоёртэй өрсөлдөх хэмжээний?

Зөндөө олон шинэ залуу тамирчид гарч ирж байна. Тэдний ур чадвар өдрөөс өдөрт дээшилж байгаа болохоор өрсөлдөөн ширүүсэх нь ойлгомжтой. Бусад жинтэй харьцуулахад харьцангуй олон тамирчинтай байна. 58 кг-д

гэхэд улсын аваргаар тавхан бөх оролцож, тойргоор барилдсан. Тэгэхэд манай 63 кг-д 11 бөх оролцсон.

-Рио-2016 Олимпын наадамд өнгөрөөд бараг л хагас жил болж байна. Гэхдээ монголчууд Олимпын наадмыг мартаагүй. Тэр дундаа чөлөөтийнхний барилдааныг мартаагүй байх. 1-2 бөх найдвартай медаль авна гэж хүлээж байсан. Гэтэл медаль хүрч чадсангүй. Тэр дундаа П.Орхонд нэлээд найдсан байх. Ер нь юу болоод, ямар шалтгааны улмаас медаль хүрч чадсангүй вэ. Өөрөө өөртөө нэг дүгнэлт хийж байгаа байх?

Харин тийм ээ, үнэхээр харамсалтай юм болсон. Ер нь бол олон жилийн турш жингээ хасч тэмцээнүүдэд оролцож байсан. Олимпын өмнө бас хоёр тэмцээнд жингээ хасаад орсон. Тийм болохоор сэргэлт сайн авч чадаагүй байх. Уг нь манай эмэгтэй багийн дөрвөн тамирчны бэлтгэлжилт үнэхээр сайн байсан. Очоод цаг уурын өөрчлөлт, цагийн зөрүү гээд нөлөө их байсан болов уу. Явцын дундаа л ядарсаар байгаад, сэргэлт авч чадаагүй сонин болчихсон шүү дээ. Түүнээс биш медаль авах бүрэн боломжтой байсан. Хэдхэн сарын, хоногийн өмнө ялж байсан бөхчүүдээ л ялагдчихсан. Хувь хүний хувьд маш их харамсаж, одоо ч дотроос гарахгүй л байна даа.

-Каори Ичог оноогоор цэвэр ялсан. Түүний дараа Монголын мундаг тамирчин гараад ирлээ гээд өөрийн тань барилдааныг илүү нарийн судалсан байх. Хэрвээ Каори Ичог тухайн үедээ ялаагүйгээр Олимпын наадамд явсан бол гэдэг бодол надад төрж л байсан. Хувь хүний л бодол

вэ, нэгэнт л ялагдчихсан юм чинь, одоо харамсах хэрэг юун. Надад том туршлага болоод л үлдсэн. Хэрвээ Каори Ичог би ялаагүй байсан бол намайг Олимпын наадамд оролцуулахгүй байсан байх. Дотоодын өрсөлдөөн их байсан. Олимпын наадам хүртэл сорилгод ороод л яваад байсан. Хүмүүс л мэдэхгүй байгаа болохоос. Би Каори Ичог ялж байж л Олимпын наадамд явах боломжтой болсон. Би тэгж л бодож байна.

-Ер нь манай чөлөөтийн жаахан муухан барилдсан. Цагийн төгсгөлд оноо алддаг, тактикийн барилдаан байхгүй юм шиг санагдсан?

Угаасаа холбоо нь хэрүүлтэй, тамирчдын сэтгэл зүйл муу байсан болохоор яаж хичээгээд үйлс нь бүтэхгүй байгаа юм чинь. Би ингэж бодож ч нэг харамсах юм. Өөртөө ч их харамсаж байгаа. Ер нь бүх юманд л харамссан. Би Оросын бөхийг л хожих ёстой байсан юм. Дөрвөн оноо бөөн авна гэж бодохгүй хоёр оноогоо аваад явчихад л болох байсан. Оросын Валерия Коблова монголчуудтай барилдаан таардаггүй учраас их эмээдэг байхгүй юу. Би дөрвөн оноо алдчихсан байсан болохоор хурдан нөхье, бүхэл дөрвөн оноо авья гэж бодсон. Түүн дээрээ алдаа гаргаад, дахиад баахан оноо нэмж алдаад барилдаан сонин болчихсон. Ер нь бол Оросын бөхийн бэлтгэл их сайн байсан. Тиймдээ ч финалдсан. Миний хувьд тэгшитгэлийн барилдаан хийсэн, арай илүү олон барилдсан учраас үдээс хойш их ядарсан. Ингээд л хоёр барилдаан хийгээд, нэг ялж, нэг ялагдсанаар медалиас мултарсан даа.

-Бэлтгэлийг өдөр болгон хийж байгаа юу. Эсвэл долоо хоногтоо тэдэн удаа гэсэн хуваарьтай байх уу?

бөхийн хөгжил муу нөлөөтэй шүү дээ?

Тамирчдын сэтгэлзүй, амжилт сөргөөр нөлөөлж байгаа шүү дээ. Энэ эв түнжингүй байдал тамирчдад үнэхээр муугаар нөлөөлдөг гэж бодож явдаг. Сая Олимпын наадмаар яав. Өмнө нь баахан хэрүүл хийгээд л явсан, түүнээсээ ч болсон уу болж өгсөнгүй. Аль болох эвтэй байгаасай л гэж бодох юм. Уг нь эрэгтэй багаас амжилт гарах бүрэн боломжтой. Би Ц.Цогтбаяр багшийг Дэлхийн бөхийн холбооноос шийтгээд, Олон улсын тэмцээнд буланд суух эрхийг нь хассан юм болов уу гэж бодож байсан юм. Гэтэл сая улсын аварга шалгаруулах тэмцээний үеэр намайг барилдаах багшийг суулгаагүй. Тэр үед би их гайхаж л байсан. Өөрийн минь хоёр багш буланд суухаар их түшигтэй санагддаг. Барилдааны үеэр хэрэгтэй зөвлөгөө өгнө. Би уг нь багштайгаа л гарна гэж бодож байтал гаргаагүй. Болохгүй л юм байлгүйдээ гэж бодоод өнгөрсөн. Г.Мандахнаран гавьяатыг барилдах үеэр ч бас жаахан муухай юм болсон. Цогоо багшийг хөөж бариад байхаар Мандахаа ахыг хурцалсан байх. Дөрвөн оноогоор гурван удаа унагаад л цэвэр ялсан. Тэгээд ч Мандахаа ах хойд үеийнхнээсээ арай илүү. Барилдааны ур чадвар, техникийн тал дээр гээд бүх зүйлээрээ илүү болохоор илүүрхсэн барилдаан болоод л өнгөрсөн дөө.

-Монголын нөхцөлд тамирчид том тэмцээнд амжилт гаргаж байх амьдрал ахуй нь жаахан дээшилдэг. Харин тэр боломжид хүрч чадаагүй нь дэмжлэггүй хорондог тал бий шүү дээ. Өөрийн тань хувьд ямархуу байна даа?

Ар гэртээ анхаарч, гэр бүлээ аваад явж байгаа өч төчнөөн тамирчин байгаа. Өөр ямар нэг ажил хийдэггүй. Гол ажил нь тэмцээн уралдаанд оролцох байдаг. Гэтэл тамирчдын цалин мөнгө үнэхээр бага. Ар гэрээ авч явах хэмжээний биш. Тэглээ гээд яах вэ дээ, дуртай, сэтгэл зүрхээ зориулчихсан юм болохоор уйгагүй зүтгэдэг өчнөөн олон тамирчин байгаа. Миний хувьд ар гэрийнхэн, хамаатан садан, найз нөхөд маань маш их дэмждэг. Энэ нь амжилт гаргахад түлхэц болж өгдөг. Ар талдаа санаа зовохгүй тэмцээн уралдаанд явна гэдэг чинь сэтгэл зүйн хувьд амар байдаг. Би "Алдар" спорт хорооны тамирчин. Эндээсээ цалингаа авчихдаг. Шигшээ баг тарчихсан болохоор одоохондоо цалин авахгүй байгаа. Гэхдээ нэг, хоёр сардаа багтаад шигшээ баг бүрдчих байх.

-Хэд хүртлээ барилдана гэж боддог вэ. Эсвэл дэлхийн аварга, Олимпын наадамд амжилт гаргахивал гэр бүлийн амьдралдаа анхаарна даа гэж боддог уу?

Одоохондоо яг тэгж төлөвлөж, бодсон юм байхгүй. Барилдана, бэлтгэлээ сайн хийнэ, амжилт гаргана л гэсэн бодолтой байгаа. Мэдээж гэр бүлийн амьдрал бусад зүйл болох цагтаа болно. Одоохондоо бол өөр янз бүрийн зүйл бодож, анхаарлаа сарниулж болохгүй шүү дээ. Зөвхөн бөхдөө, барилдаандаа, бэлтгэлдээ л анхаарлаа хандуулах хэрэгтэй байна.

СПОРТ

FOOTBALL NEWS

МЕССИ, СУАРЕС, НЕЙМАР

гурав хосолсноосоо хойш
300 гоол орууллаа

Н.ПУНЦАГБОЛД

Испанийн цом буюу "Копа дэ Рей" тэмцээний 1/8 шигшсэн хару тоглолтууд болж байгаа билээ. Өнгөрсөн шөнө "Реал" тэргүүтэй зургаан багийн гурван тоглолт болсноор шилдэг наймын нэр эцэслэн тодорч байгаа юм. Тэгвэл өнгөрсөн лхагва гарагийн шөнө дөрвөн тоглолт болж, шөвгийн наймд үлдэх тав дахь баг тодорхой болсон. Каталаны "Барселона" багийнхан дэлхийн шилдгийг тодруулах ёслолд ч оролцогчгүйгээр энэ тоглолтод бэлтгэсэн билээ. Тодруулбал, Олон улсын хөлбөмбөгийн холбоо 2016 оны дэлхийн шилдгүүдийг тодруулах ёслолыг Швейцарийн Цюрих хотноо зохион байгуулсан. Энэхүү ёслолд "Барселона"-гийнхан очоогүй юм. Месси дэлхийн шилдэг хөлбөмбөгчний сүүлчийн шатанд Роналдо, Гризманн нартай тунаж үлдсэн. Тэгвэл бэлгэдийн шигшээд Пике, Иньеста, Месси, Суарес нар багтсан. Гэвч тэд энэ бүхнийг үл тоож, "Атлетик" клубын эсрэг цомын тоглолтод бэлтгэсэн билээ. Түүнийхээ ачаар талбайдаа "Атлетик" клубыг 3:1-ээр буулгаж авч чадсан юм. Ингэснээр хоёр тоглолтын нийлбэр дүнгээр 4:3-аар хожиж, шөвгийн наймд шалгарлаа. Тоглолтын 35 дахь минутад Суарес гоолдож, тооны харьцааг нээсэн. Улмаар 48 дахь минутад Неймар торгуулийн цохилтоос нэгийг нэмсэн байна. Харин 51 дэх минутад Саборит тооны харьцааг ойртуулсан ч 78 дахь минутад Месси хожлын гэж хэлж болохоор гоолыг оруулжээ. Өчигдрийн байдлаар "Атлетико", "Реал Сосьедад", "Алавес", "Алькоркон", "Барселона" тэргүүтэй таван баг үлдсэн. Харин "Барселона"-гийн энэ хожлын хажуугаар Неймар, Суарес нар гоолдсоноор хэд хэдэн үзүүлэлтийг гаргалаа. Тодруулбал, Суарес энэ тоглолтод нэг гоол оруулснаар "Барселона"-гийн төлөө 100 дахь гоолоо оруулсан юм. Тэрбээр Каталаны багийн төлөө 120 тоглолтод оролцохдоо 100 гоол оруулж, 60 гоолын дамжуулалт өгөөд байгаа билээ. Мөн энэ тоглолтод Неймар торгуулийн цохилтоор нэг гоол оруулсан. Түүнд Месси торгуулийн цохилтоо найр тавьж байж, Бразил эрийн гоол оруулалгүй 11 тоглолтын цуврал болсон "цангаа"-г тайлсан юм. Харин дэлхийн хамгийн шилдэг довтолгооны хослол болчихоод байгаа Месси, Неймар, Суарес гурав "Барселона"-д нэгдсэнээсээ хойш 300 гоол орууллаа. Өчигдөр тэд тус бүртээ нэг гоолыг оруулснаар энэхүү агуу амжилтыг үзүүлсэн юм. Месси энэ хугацаанд 124 гоол оруулсан бол Суарес 100-г хийгээд байгаа. Харин Неймар 76 гоол оруулсан амжилттай явж байна.

Улаанбаатарт:

Маргааш
Эдөр -16
Шөнө -24

Нөгөөдөр
Эдөр -17
Шөнө -26

Өдрийн зурхай

ӨВЛИЙН ДУНД
ЦАГААН ХУЛГАНА
САРЫН ДОЛООН УЛААН
МЭНГЭТЭЙ ЦАГААН
ХУЛГАНА ӨДӨР

Наран ургах шингэх: 08.29-17.27

Үс засуулбал: Өвчин ирнэ



Тухайн өдөр луу, бич жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр гэмтнийг шийтгэх, гарагийг тахиж, хүүхэд үрчлэн авах, урлан бүтээхэд сайн. Улаа гаргах, хиншүү хярвас гаргах, төлөг гавих, морь уралдахад муу. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, туулай, морь, бич, тахиа болой. Хол газар яваар одогсод зүүн урагш мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

Терри "БОРНМУТ" РУУ
явахыг хүсэхгүй байна

"Челси" клубын ахлагч, домогт тоглогч Жон Терри өөр баг руу явах сонирхолтой байгаа билээ. Тэгвэл өдгөө 36 настай тоглогчийг "Борнмут" сонирхож байгаа талаар мэдээлэл гарсан. Тэд Терриг зээлээр авч, төвийн хамгаалалтын шугамаа зузаатгаад, Натан Акег "Челси" руу буцаах сонирхолтой байгаа аж. Гэвч Терри "Борнмут" руу явахыг хүсэхгүй байгаагаа мэдэгджээ. Ерөөс Терри Английн өөр багт очих бодолгүй байгаа юм байна.

"Интер" ВЕРАТТИГИЙН төлөө 78 СЯЯ ЕВРО санал
болгоход бэлэн

Италийн алдарт "Интер" клуб энэ улирлын төгсгөлд "ПСЖ"-гээс Марко Верраттиг худалдаж авах гэж байгаа ажээ. Мөн түүнийг Английн "Челси",

Германы "Байерн Мюнхэн" клубүүд сонирхож байгаа юм. Италийн баг өдгөө 24 настай хөлбөмбөгчний төлөө 78 сая евро төлөхөд бэлэн байгаа гэнэ.

Вератти одоогоор Францын аварга шалгаруулах тэмцээнд 14 тоглолтод оролцож, хоёр гоол оруулж, нэг оновчтой дамжуулалт өгөөд байна.

"АРСЕНАЛ" Жиру, Кошельни, Коклен нарын
ГЭРЭЭГ СУНГАЛАА

Английн "Арсенал" клуб Франц хөлбөмбөгчид болох Оливье Жиру, Лоран Кошельни болон Франсис Коклен нарын гэрээг сунгалаа. Гэхдээ яг хэдийн жилийн гэрээ байгуулсан нь тодорхойгүй байгаа юм. Ямар ч байсан урт хугацааны гэрээ байгуулсан хэмээн мэдээлж байна. "Манай багийн гурван чухал тоглогч урт хугацаанд энд тоглох болсонд би маш их

баяртай байна. Франсис сүүлийн жилүүдэд маш ихээр сайжирч байгаа бөгөөд өдөр бүр бэлтгэлтдээ анхаардаг. Оливье туршлагатай тоглогч. Лоран манай багийн гол тоглогчдын нэг. Би түүнийг дэлхийн хамгийн шилдэг хамгаалагчдын нэг гэж боддог. Энэ бол манай багийн хувьд сайхан мэдээ" хэмээн "Арсенал"-ын дасгалжуулагч Арсен Венгер ярьжээ.

TENGIS



Аз жаргал, зовлон гуниг, хайр дурлал, хардалт, амжилт, бүтэлгүйтэл гээд л хар, цагаан хосолж байдаг хүний амьдралд бид төрөхдөө "Амьдралын сурах бичиг"-ээ өвөртлөөд ирдэг бол хэчнээн сайхан! Өөрийн биеэр туулж байж л амьдралын зах зухаас мэдэж, сурч, туршлагажиж ухаардаг. Энэ бол "Амьдралогч" юм. Тэгвэл амьдралынхаа 2 дахь үеийн хямралд орсон гэр бүлийн хос, амжилттай яваа ч заяаны ханна хараахан олоогүй бүсгүй, залуу халуун насныхаа алдаа, оноог дэнслүүлэн яваа оюутан охин болон киноны бусад дүрүүдийн аз жаргалын төлөөх тэмцэл болон тэдний санаанд оромгүй сонголтуудыг "Амьдралогч" романтик инээдмийн уран сайхны киноноос үзээрэй.



Assassin's Creed буюу Алуурчны үнэмшил видео тоглоомоос сэдэвлэн бүтээв.



Жазз хөгжимчин Сибастян жүжигчин болох хүсэл мөрөөдөлтэй Миа бүсгүйд дурлана. Миа киноны шалгаруулалтуудад орохын хажуугаар кино одуудад кофе зөөдөг бол жазз хөгжимчин Сибастян ядруухан баранд коктэйлийн үдэшлэгийн хөгжим тоглож амь зогоодог байв. Амжилтад ойртохын хэрээр тэд тэдний эмзэгхэн хайрыг сэвтээх хүнд шийдвэрүүдийг гаргах хэрэгтэй болно.